



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 12  
сарын 26 өдөр

Дугаар 31-1/163

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224003356



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>22</sup> он <sup>12</sup> дугаар  
сарын <sup>23</sup> ны өдөр

Дугаар ХАТ/3128

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>103</sup> хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



  
Д.АМАРБАЯСГАЛАН

000225016458

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 57 дугаар тэмдэглэлд:

“ХХ.ХЭЛЭЛЦСЭН нь: Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.12.22 № 1/6466

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай,  
Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай  
хуулийн төслүүд болон дагалдах бусад хуулийн  
төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20  
дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын  
Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151605758  
A5 Файл.2022



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2022.12.09 № 01/8386

танай 2022.12.01-ны № 1/6067 -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**



Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай,  
Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай  
хуулийн төслүүд болон дагалдах бусад хуулийн  
төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20  
дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу  
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч  
байна.

Хүндэтгэсэн,



Б ЖАВХЛАН

9761001701



## **БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” гэж, 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Тус хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байх” зорилтыг дэвшүүлж, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.47-д “...аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4-т Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ” гэж, мөн 2.6-д заасан Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох зорилтын хүрээнд “... соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал

жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслийг боловсруулан, батлуулахаар тусгажээ.

## 1.2. Практик шаардлага

Бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлага үүссэнийг илтгэх хэд хэдэн практик шаардлага үүссэн байна. Үүнд:

1. Үндэсний статистикийн газрын тоон мэдээллээс харахад 2019 онд Монгол Улсад 577.3<sup>1</sup> мянган гадаадын иргэн аялал жуулчлалын зорилгоор ирсэн бол Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор 2020 онд энэ тоо 58.9<sup>2</sup> мянга болж өмнөх оны энэ үеэс даруй 90 орчим хувиар, 2021 онд 33.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 43.8%-иар тус тус буусан байна.

Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан.

Монгол Улсад ирсэн нийт жуулчдын 70 орчим хувь нь II, III дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирсэн байна. Ялангуяа 7 дугаар сард Монгол Улсад зочлох жуулчдын тоо харьцангуй нэмэгддэг буюу ойролцоогоор 100 орчим мянган жуулчин ирдгээс дийлэнх жуулчин Улаанбаатар хотод болон орон нутагт очиж баяр наадам үздэг<sup>1</sup> байна. Мөн жил бүр 10 мянга орчим жуулчин наадмын нээлт үзэхээр захиалга өгдөг байна.

Эдгээр тоон мэдээллээс үзэхэд Монгол Улсад ирж буй жуулчдын дийлэнх нь монголын соёлын өв болох монгол наадам (үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харваа) үзэхээр Монгол Улсыг зорин ирдэг бөгөөд нөгөөтээгүүр манай орны эрс тэс цаг агаарын байдал болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэрэг нь өвлийн улиралд ирэх жуулчдын тоог бага байхад нөлөөлдөг.

Түүнчлэн Үндэсний статистикийн хорооны 2020 оны судалгаагаар “Улс нүүдлийн соёл, уламжлалаараа жуулчдыг татах эрмэлзлээ улам бүр өргөжүүлэн Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татах үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна” гэсэн дүгнэлт гаргасан байна.

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хурдан морины уралдааныг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн насны ангиллаар зохион байгуулна.” гэж заасан бөгөөд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 34 дүгээр тогтоолоор “Хурдан моринд тавих

<sup>1</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 оны 2 дугаар сар.

<sup>2</sup> мөн тэнд

ерөнхий шаардлага” буюу MNS6464:2014 стандартаар хурдан морины сэрвээний өндрийн дээд хэмжээг тогтоож, Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын “Их Хурд” уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаан зохион байгуулахад тус стандартыг мөрдөхөөр заасан.

Мөн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/49 дүгээр тушаалаар Баталсан Монгол үүлдэр, омгийн адуу стандарт /MNS4099:2010/-аар Монгол морьдын үүлдэрлэг байдал буюу гадаад шинжийг нь тогтоосон байна.

Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын “Их Хурд” уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаанд дээрх стандартад нийцсэн адууг уралдуулах бөгөөд монгол эрлийз морьдыг сэрвээний өндөр, үүлдэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялгаварлаж хурдан морины уралдаанаас хасах хандлагатай байдаг нь маргаан дагуулсаар байдаг.

Мөн сэрвээний өндөр, монгол морины үүлдэрлэг байдал зэргийг үндэслэн морийг хурдан морины уралдааны бүртгэлд бүртгээгүй, уралдуулахаас хассан зэрэг нь тодорхойгүй, ил тод байдаггүй учраас олон уяачдын хөдөлмөр, хөрөнгийг үнэгүйдүүлж байна гэж үзэхээр байна.

3.Түүнчлэн хурдан морины уралдааныг дагаж унаач хүүхдийн эрхийн асуудал зайлшгүй хөндөгддөг. Судалгаанаас үзэхэд 2012-2014 оны хооронд Гэмтэл согог судлалын үндэсний төвд 941 хүүхэд мориноос унаж гэмтэл авсны улмаас эмнэлгийн яаралтай тусламж авснаас хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо 605, нас барсан хүүхдийн тоо 6 байжээ<sup>2</sup>.

1996-2006 онд 17 хүүхэд хурдан морины уралдааны явцад мориноосоо унаж амь эрсэдсэнээс 6 нь зун (намар), 2 нь хавар (өвөл) тохиолдсон байх бөгөөд үлдсэн 9 тохиолдол хэзээ болсон нь тодорхойгүй байна.<sup>3</sup> Үүнээс үзэхэд мориноос унаж амь насаа алдах нь хаврын төдийгүй зуны уралдааны үед ч элбэг тохиолддог байна.

Хэдийгээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолоор жил бүрийн арваннэгдүгээр сарын 1-ээс тавдугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээн зохион байгуулахыг хориглосон боловч 2022 оны Сар шинийн баярын өдрүүдэд 7 аймагт хурдан морины бэсрэг болон бооцоот уралдаан зохион байгуулсан<sup>4</sup> тухай Хүний эрхийн үндэсний комисс мэдээлсэн бөгөөд 2022 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр Архангай аймгийн Ихтамир сумын Элстэй гэх газар хурдан морины уралдаанд бэлдэж байсан 12 настай эрэгтэй хүүхэд мөсөн дээр унаж, моринд өшиглүүлэн дунд чөмгөө хугалсан тохиолдол байна.<sup>5</sup>

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичигт туссан зорилтыг хэрэгжүүлэх, унаач хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр өв соёл, түүхэн уламжлалаа тээж үлдэх, соёл, уламжлалаараа жуулчдыг татах шаардлага байгаагаас гадна хурдан морь эзэмшигч, уяачдад аль ч улиралд морио уралдуулах, Үндэсний баяр наадамд



уралдуулж чаддаггүй морио уралдуулах бололцоог бий болгох, олон улсын жишигт нийцсэн морин тойруулга байгуулж, бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Бооцоот морин уралдааны эрх зүйн орчныг бий болгох зорилгоор анхдагч хуулийн төсөл боловсруулна. Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоож, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Мөн бооцоот морин уралдааны харилцаанд оролцох бусад этгээдүүд буюу бооцоо тавьж оролцогч, морин уралдааны унаач, уяачдын эрх зүйн байдлыг тодорхойлно. Тухайлбал унаач нь морь унах, уралдуулах чадвар, дадлыг эзэмшиж, бооцоот морин уралдааны унаачийн эрх авсан, 18 насанд хүрсэн этгээд байх бол уяач нь морин тойруулгын гишүүн байхаар зааж, морин тойруулгын дүрмийн дагуу өөрийн өмчлөлийн морийг уралдаанд оролцуулах зохицуулалтыг тусгана.

Түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулагчийн төлөх татварын төрөл, хувь хэмжээг тогтоож, төвлөрүүлсэн татварын орлогын зохих хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаа болон соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад ажиллагаанд тус тус зарцуулахаар боловсруулна.

Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна;

-Улсын төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэх, мөн татварын орлогын зарим хэсгийг нийгэм, соёлын үйл ажиллагаанд зарцуулах;

-Морины эзэн, уяачид Үндэсний их баяр наадам, бүсийн хурдан морины уралдаанаас гадна бусад улиралд морио уралдуулах, орлого олох, мөн морины уралдааныг олон ангиллаар зохион байгуулах боломжтой болох тул хурдан морины уралдаанд уралдуулж чаддаггүй эрлийз адуугаа бооцоот морин уралдаанд уралдуулах боломжтой болно;

-Бооцоот морин уралдааны унаач нь зөвхөн 18 насанд хүрсэн хүн байх тул хүүхдийн эрхийг зөрчсөн тухай асуудал яригдахгүй бөгөөд моринд гарамгай хүмүүс шинээр ажлын байртай болох боломжтой;

-Бооцоо тавьж оролцогч нь 18 насанд хүрсэн хүн байх буюу Монгол Улсын, эсхүл гадаадын иргэн байх боломжтой. Морин спортыг олон нийтэд сурталчлах, хөгжүүлэх, морь шинжиж мэддэг хүмүүс бооцоо тавих зэргээр чөлөөт цагаа сонирхолтой өнгөрүүлэх боломжтой болно;

-Уралдаан үзэгч нь бүсийн болон улсын хурдан морины уралдаангүй цагт ч морин уралдааныг морин тойруулгад очиж, эсхүл өргөн нэвтрүүлгээр дамжуулан үзэж сонирхох боломжтой болох бөгөөд дотоодын иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх, гадаадын жуулчид зорьж очих газар нэмэгдэх зэрэг ач холбогдолтой байна.

**Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон Казиногийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулах бөгөөд Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулна.

-----oO-----

## ТАНИЛЦУУЛГА

Бооцоот морин уралдааны тухай  
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.47-д “Монгол Улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулж, гадаад сурталчилгааг сайжруулан, аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.4-т заасан Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ” гэж, мөн 2.6-д заасан Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох зорилтын хүрээнд “үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслийг боловсруулан, батлуулахаар тусгажээ.

Ийнхүү дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэхээр Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсрууллаа.

Монгол үндэстний дэлхийд бахархах өв болох морин уралдааныг бооцоот уралдааны шинэ төрлийн спорт болгон хөгжүүлэх, бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгох хүрээнд хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа.

Бооцоот уралдааны үйл ажиллагааг хууль ёсоор, хариуцлагатай эрхлэх боломжийг бий болгох үүднээс бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх нийтийн эрх зүйн этгээд буюу “Монголын морин уралдааны холбоо”-г хуулиар байгуулж, түүний чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоож, бооцоот уралдааны үйл ажиллагааг нээлттэй, хариуцлагатай, ил тод байдлаар зохион байгуулах, оролцогчдод тэгш боломж олгох, бооцоот морин уралдааны оролцогч, уяач, унаачийн эрх ашгийг тэнцвэртэй хангах зохицуулалтыг тусгасан болно.

Холбоо нь морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлалыг батлахаар тусгаж, мөн уяач морин тойруулгын гишүүнээр элссэнээр морин тойруулгын дүрмийн дагуу уралдаанд морио уралдуулах бөгөөд ингэснээр морины эзэн, уяачдад Үндэсний баяр наадам, бүсийн хурдан морины уралдаанаас гадна бусад улиралд морио уралдуулж, орлого олох, мөн морины уралдааныг олон ангиллаар зохион байгуулах боломж бий болно гэж үзлээ.

Түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах үүднээс бооцоот морин уралдааны морийг морь унах, уралдуулах чадвар, дадлыг эзэмшсэн, 18 насанд хүрсэн хүн унах бөгөөд тухайн шаардлагыг хангаагүй хүнээр бооцоот уралдааны морь унуулахыг хориглох зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр унаач хүүхдийн эрхийг хөндөхгүйгээс гадна морь мэддэг, унаж чаддаг хүмүүс шинээр ажлын байртай болох боломж бий болно гэж үзлээ.

Өв соёл, түүхэн уламжлалаараа дамжуулан эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд уралдаан зохион байгуулагч нь бооцоот морин уралдаан зохион байгуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй үйл ажиллагаа явуулахыг хориглосон бөгөөд тэр дундаа ашиг хонжоо олох зорилгоор казино, бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглосон болно.

Олон нийтийг бооцоот тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх зорилгоор оролцогчийг бооцоот уралдаанд зээлээр оролцуулах, морин тойруулгын цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглосон зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох бөгөөд бооцоот морин уралдааны нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 60 хувиар онцгой албан татвар ногдуулах тул давхардуулан аж ахуйн нэгжийн орлогы албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй байх зарчмыг баримталсан болно. Мөн тоглогчийн хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй байхаар тусгалаа.

Мөн Холбооны төлсөн Онцгой албан татвараас төвлөрүүлсэн орлогын зарим хэсгийг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахаар Ирээдүйн өв сан болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх санд төвлөрүүлэхээр тусгасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

Хуулийн төсөлд төрийн захиргааны төв байгууллагууд, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын саналыг авсан. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамны [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) албан ёсны цахим хуудаст байршуулан иргэд, олон нийт судалж, танилцан, санал өгөх бололцоогоор хангасан болно.

Төсөл  
2022.12.22

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдаан зохион байгуулах, оролцогч, уяач, унаачийн эрхийг хангах, бооцоот морин уралдаан зохион байгуулах хуулийн этгээдийн чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Бооцоот морин уралдааны хууль тогтоомж

2.1.Бооцоот морин уралдааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“бооцоо” гэж морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааны үр дүнгийн талаар дэвшүүлсэн таамаг нь таарсан тохиолдолд дүрэмд зааснаар өсгөж авах нөхцөлтэйгөөр эрсдэлээ өөрөө хариуцаж, зохион байгуулагчид сайн дураараа шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг;

3.1.2.“бооцоот морин уралдаан” /цаашид “бооцоот уралдаан” гэх/ гэж эрх бүхий этгээд тогтоосон дүрмийн дагуу морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааныг;

3.1.3.“бооцоот уралдаан зохион байгуулах” гэж бооцоот морин уралдааны үр дүнгийн талаар оролцогчдоос бооцоо цуглуулах, уралдааны үр дүнг гарсны дараа оролцогчдын хүртэх хонжворын хэмжээг тооцоолж оролцогчдод олгох зэргээр бооцоот морин уралдааны үйл ажиллагааг эрхлэхийг;

3.1.4.“оролцогч” гэж бооцоот уралдааны үр дүнгийн талаар аз туршсан таамаг дэвшүүлж, учирч болох эрсдэлээ хүлээн зөвшөөрч, морин уралдаанд бооцоо тавьж оролцож байгаа хувь хүнийг;

3.1.5. “зөвлөл” гэж Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан байгууллагыг;

3.1.6. “Монголын морин уралдааны холбоо” гэж энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг;

3.1.7. “морин тойруулгын цогцолбор” гэж бооцоот морин уралдаан зохион байгуулахад зориулсан зам талбай, барилга байгууламж, тотализатор, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бүхий цогцолбор байгууламжийг;

3.1.8. “унаач” гэж бооцоот морин уралдаанд морийг унаж, уралдуулах хүнийг;

3.1.9. “уяач” гэж бооцоот морин уралдаанд уралдуулж байгаа морины өмчлөгчийг;

3.1.10. “тотализатор” гэж бооцоо цуглуулах, бооцооны дүнг гаргах, бооцоог хуваарилахад ашигладаг программ хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн иж бүрдэл бүхий тооцоолуурыг;

3.1.11. “хонжворт” гэж Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.10-т заасныг.

#### **4 дүгээр зүйл. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1. бооцоот уралдааныг нээлттэй, шударга, хариуцлагатай, ил тод байдлаар зохион байгуулах, оролцогчдод тэгш боломж олгох;

4.1.2. бооцоот уралдаанд оролцогчид үнэнч шударгаар өрсөлдөх, ёс зүйтэй байх;

4.1.3. олон нийтийг бооцоот тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх;

4.1.4. нийтийн дэг журмыг хангах, бооцоот тоглоомыг гэмт хэргийг дэмжих хэрэгсэл болохоос урьдчилан сэргийлэх.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ БООЦООТ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ**

#### **5 дугаар зүйл. Бооцоот уралдаан зохион байгуулах**

5.1. Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.

5.2. Бооцоот уралдааны зориулалтаар морин тойруулгын цогцолбор байгуулах байршлыг Засгийн газар тогтооно.

5.3. Бооцоот уралдааныг энэ хуулийн 6.1-д заасан шаардлагад нийцсэн морин тойруулгын цогцолборт зохион байгуулна.

5.4.Энэ хуулийн 5.2-т заасны дагуу тогтоосон байршилд морин тойруулгын зориулалтаар газар ашиглах зөвшөөрлийг 15 жилийн хугацаагаар холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд байгуулах бол чөлөөт бүсийн захирагч олгож, мөн хугацаагаар сунгана.

5.5.Зөвлөл нь бооцоот уралдааны эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.

5.6.Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ:

5.6.1.Холбооны танилцуулга;

5.6.2.морин тойруулгын барилга байгууламжийн төсөл болон бооцоот уралдааны үйл ажиллагаа эрхлэх төсөл;

5.6.3.Холбооны дүрэм;

5.6.4.харилцагч банкны тодорхойлолт.

5.7.Холбоо нь морин тойруулгын салбар байгуулах бол тухай бүр Засгийн газраас зөвшөөрөл авна.

5.8.Бооцоот уралдаанд уралдах хурдан морьдын ангилал, уралдааны төрөл, хэлбэрийг Бооцоот морин тойруулгын дүрмээр тогтооно.

5.9.Энэ хуулийн 5.1-д зааснаас бусад этгээд бооцоот уралдаан зохион байгуулахыг хориглоно.

5.10.Холбоо бооцоот уралдаан зохион байгуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй үйл ажиллагаа болон казино, бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно.

5.11.Бооцоот уралдааны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Бооцоот морин тойруулгын дүрмээр зохицуулна.

## **6 дугаар зүйл.Морин тойруулгын цогцолбор**

6.1.Морин тойруулгын цогцолбор нь дараах шаардлагыг хангасан байна:

6.1.1.бооцоот уралдааны үйл ажиллагаанд зориулсан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, аюулгүй байдлыг хангасан зохистой дэд бүтэц бүхий морин тойруулгын үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралт, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан байх;

6.1.2.бооцоот уралдааны үйл ажиллагаанд зориулсан олон улсын стандартад нийцсэн, үйлдвэрийн баталгаа бүхий зориулалтын тоног төхөөрөмж, тотализатор, техник, хэрэгсэл, программ хангамжаар хангагдсан байх;

6.1.3.морин тойруулгын ажилтан нь бооцоот уралдааны үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байх;

6.1.4.оролцогчоос бооцоо хураах, бэлэн мөнгө авах, өгөх мөнгөн кассын хэсэг, бооцоот уралдаан зохион байгуулж байгаа танхим бүрт дуу-дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан байх;

6.1.5.Зөвлөлөөс баталсан шаардлагыг хангасан байх.

6.2.Бооцоот уралдааны тотализатор нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай холбогдсон байх бөгөөд бооцоо, хонжворын мэдээлэл нь тухай бүр бүртгэгдсэн байна.

6.3.Оролцогчийг бооцоот уралдаанд зээлээр оролцуулах, морин тойруулгын цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

## **7 дугаар зүйл.Бооцоот морин уралдааны журам**

7.1.Бооцоот уралдааны үйл ажиллагаанд энэ хуульд зааснаас гадна дараах дүрэм, аргачлалыг дагаж, мөрдөнө:

7.1.1.морин тойруулгын дүрэм;

7.1.2.бооцоот морин уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлал;

7.1.3.бооцоот морин уралдааны мөнгөн кассын дүрэм;

7.1.4.бооцоот морин уралдааны ёс зүйн дүрэм.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.

7.3.Холбоо нь бооцоот уралдаанд оролцох унаач, уяач, морины шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Шударга бусаар өрсөлдөхийг завдсан болон шударга бусаар өрсөлдсөн бол морин тойруулгын дүрэм, бооцоот морин уралдааны ёс зүйн дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

7.4.Холбоо нь Бооцоот морин уралдааны ёс зүйн дүрмийг зөрчсөн уяач, унаач, морин тойруулгын бусад ажилтныг ажлаас халах, уралдаанд оролцохыг хугацаагүйгээр, эсхүл тодорхой хугацаагаар хязгаарлах зэрэг арга хэмжээг авна.

7.5.Бооцоот уралдаанд оролцогчийн тавьж болох бооцооны дээд хэмжээг Зөвлөл батална.

## **8 дугаар зүйл.Бооцоот уралдаанд хориглох үйл ажиллагаа**

8.1.Холбоонд бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлийг хориглоно:

8.1.1.оролцогч, уяач, унаачийг хууран мэхлэх зорилгоор уралдааны үр дүнг өөрчлөх, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хохироох;

8.1.2.хожсон оролцогчийн хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналыг олгохоос зайлсхийх, татгалзах;



8.1.3.морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог хуваарилах дүрэм, бооцоот уралдааны мөнгөн кассын дүрмийг зөрчих;

8.1.4.оролцогчоор дамжуулан бооцоо тавих, оролцогчийн бооцоо тавих шийдвэр гаргахад дотоод мэдээллийг ашиглуулах, давуу тал үүсгэх боломж олгох;

8.1.5.санаатайгаар, эсхүл зохион байгуулалттайгаар шударга бусаар бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх, уралдаанд оролцож байгаа унаач, морийг түрүүлүүлэх, хожигдуулахаар урьдаас үгсэн хуйвалдах;

8.1.6.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан агуулгатай, эсхүл мөрийтэй тоглоомын донтолт үүсгэхүйц хэлбэрээр зар сурталчилгаа явуулах;

8.1.7.Зөвлөлийн хориглосон бусад үйл ажиллагаа.

8.2.Оролцогч, уяач, унаач, Холбоо болон бусад этгээд бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх зорилгоор хуйвалдах, шударга бус үйлдлээр бооцоот уралдааны бусад оролцогчдын эрхийг зөрчих, хохирол учруулахыг хориглоно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ОРОЛЦОГЧ, УЯАЧ, УНААЧ**

### **9 дүгээр зүйл.Оролцогч**

9.1.Бооцоот уралдаанд оролцогч нь 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

9.2.Холбоо нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу оролцогчийг таньж мэдэх үүрэгтэй байна.

### **10 дугаар зүйл.Уяач**

10.1.Бооцоот уралдаанд морио уралдуулах уяач Холбооны гишүүн байна. Бооцоот уралдаанд Холбооны гишүүнчлэлтэй уяач морио уралдуулах эрхтэй байна.

10.2.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа морин тойруулгын дүрмийн дагуу Холбоонд бүртгүүлэх бөгөөд нэг морины бүртгэлд хоёроос дээш уяач бүртгэхгүй.

10.3.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа сайн дураар даатгуулж болно.

10.4.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахад морин тойруулгын дүрмийг мөрдөх бөгөөд дүрмээр зохицуулаагүй харилцааг гэрээгээр тохиролцож болно.

### **11 дүгээр зүйл.Унаач**

11.1.Бооцоот уралдааны унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 18 насанд хүрсэн хүн байна.

11.2.18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдаанд морь унуулахыг хориглоно.

11.3.Холбоо унаачийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэлээр хангана.

11.4.Унаач ослын даатгалд даатгуулсан байна.

11.5.Унаачийг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бэлтгэх бөгөөд холбогдох харилцааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.

11.6.Бооцоот уралдааны аюулгүй байдлын дүрмийг Зөвлөл батална.

11.7.Уралдуулсан морь нь бооцоот уралдаанд түрүүлсэн болон бооцоот уралдаанд шагналт байранд орсон тохиолдолд морин уралдааны бооцооноос олсон орлогоос уяач болон унаач нарын хүртэх хувь хэмжээг бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлалын дагуу олгоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОРИН УРАЛДААНЫ ХОЛБОО, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **12 дугаар зүйл.Морин уралдааны холбоо, түүний гишүүнчлэл**

12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

12.2.Дараах этгээд Холбооны гишүүн байж болно:

12.2.1.Монгол Улсын иргэн;

12.2.2.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

12.3.Гишүүнчлэлийн нөхцөл, шаардлага, хураамжийн хэмжээг Холбооны дүрмээр тогтооно.

12.4.Гишүүнчлэлийн эрхийг хуульд заасны дагуу бэлэглэх, өв залгамжлах зэргээр бусдад шилжүүлж болно.

12.5.Холбооны санхүүжилт нь гишүүнчлэлийн хураамж, хандив, бооцооны орлогоос бүрдэнэ.

12.6.Холбооны санхүүгийн тайлан нээлттэй байх бөгөөд санхүүгийн аудитыг жил тутамд хийлгэж, гишүүддээ болон олон нийтэд тайлагнана.

12.7.Холбоо нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутам орлогоо байршуулна.

### **13 дугаар зүйл.Морин уралдааны холбооны чиг үүрэг**

13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:

13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;

13.1.2.морь арчлах, амраах, сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;

13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;

13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;

13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.

13.2.Холбоо дараах үүрэгтэй:

13.2.1.хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

13.2.2.зохих татварыг хуульд заасан журам, хэмжээгээр төлөх;

13.2.3.зориулалтын техник хэрэгсэл, сүлжээ, программ хангамж, хяналтын дууны, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

13.2.4.хууран мэхлэх, залилах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;

13.2.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний болон олон улсын байгууллагаас тавьж байгаа шаардлагыг биелүүлэх;

13.2.6.бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалыг оролцогчид болон олон нийт танилцах боломжтой байдлаар нээлттэй байлгах, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, бүртгүүлэх;

13.2.7.хуульд заасан бусад.

13.3.Холбоо бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох үүрэгтэй.

### **14 дүгээр зүйл.Морь арчлах, амраах, сэрүүцүүлэх үйл ажиллагаа**

14.1.Холбоо холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн морь арчлах, амраах, сэрүүцүүлэх үйлчилгээ эрхэлж болно.

14.2.Үйлчилгээний журам, үнэ тариф, гэрээний нөхцөлийг Холбоо тогтооно.

14.3.Үйлчилгээний улмаас учирч болох эрсдэл, хариуцлагын талаар гэрээнд тусгана.

## **15 дугаар зүйл.Морин уралдааны холбооны дүрэм**

15.1.Холбооны дүрэмд дараах зүйлийг тусгана:

- 15.1.1.зорилго, үйл ажиллагааны чиглэл;
- 15.1.2.дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, журам;
- 15.1.3.бүх гишүүдийн хуралдааны журам;
- 15.1.4.удирдах зөвлөлийн хуралдааны журам;
- 15.1.5.холбооны гишүүний эрх, үүрэг;
- 15.1.6.гишүүн элсүүлэх, гишүүнчлэлээс хасах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, журам, гишүүнчлэлээс хасах үндэслэл;
- 15.1.7.ээлжит бус хурал зарлан хуралдуулах, үндэслэл журам;
- 15.1.8.гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ;
- 15.1.9.бусад.

## **16 дугаар зүйл.Холбооны удирдлага, зохион байгуулалт**

16.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

16.2.Холбооны удирдах байгууллага нь Удирдах зөвлөл байна.

16.3.Холбоо нь хяналтын хороо болон холбооны өдөр тутмын үйл ажиллагааг явуулах гүйцэтгэх удирдлагатай байна.

## **17 дугаар зүйл.Холбооны Бүх гишүүдийн хурал**

17.1.Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулах бөгөөд ээлжит бус хурал зарлан хуралдуулахтай холбогдсон харилцааг Холбооны дүрмээр зохицуулна.

17.2.Бүх гишүүдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 17.2.1.холбооны дүрмийг батлах;
- 17.2.2.холбооны бодлого, хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлох;
- 17.2.3.ёс зүйн дүрмийг батлах;
- 17.2.4.бооцоот морин тойруулгын дүрмийг батлах;
- 17.2.5.бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлалыг батлах;
- 17.2.6.бооцоот уралдааны мөнгөн кассын дүрмийг батлах;

17.2.7.Холбооны Удирдах зөвлөл, Холбооны Хяналтын хороо/цаашид "Хяналтын хороо" гэх/-ийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;

17.2.8.Холбооны Удирдах зөвлөл, Холбооны Хяналтын хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

17.2.9.Холбооны гүйцэтгэх удирдлагыг сонгох, чөлөөлөх;

17.2.10.морин тойруулгын салбар байгуулах шийдвэр гаргах;

17.2.11.Холбооны гишүүнчлэлийн төрөл, хураамжийн хэмжээг тогтоох;

17.2.12.Холбооны жилийн төсвийн төслийг батлах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

17.2.13.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

17.3.Бүх гишүүдийн хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө Холбооны Удирдах зөвлөл өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

17.4.Бүх гишүүдийн хурал асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

## **18 дугаар зүйл.Холбооны Удирдах зөвлөл**

18.1.Холбооны Удирдах зөвлөл нь Бүх гишүүдийн чөлөөт цагт Холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

18.2.Холбооны Удирдах зөвлөл 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

18.3.Холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр хоёроос дээш удаа дараалан сонгогдохгүй.

18.4.Холбооны Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.4.1.Холбооны жилийн ажлын төлөвлөгөө, Холбооны бодлого, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

18.4.2.Холбооны бодлого, хөгжлийн хөтөлбөр, Холбооны дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

18.4.3.Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;

18.4.4.Холбооны жилийн төсвийг боловсруулах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

18.4.5.Холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гишүүдээс гаргасан санал, гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх;

18.4.6.Холбооны ажлын албаны бүтэц, орон тоо, ажилтны цалин хөлсний хэмжээг тогтоох;

18.4.7.Холбооны санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

18.4.8.Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

18.5.Холбооны Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүний дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

18.6.Холбооны Удирдах зөвлөл асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

18.7.Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

18.8.Холбооны Удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно.

## **19 дүгээр зүйл.Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг**

19.1.Гүйцэтгэх удирдлага дараах эрхтэй:

19.1.1.Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

19.1.2.Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд Холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

19.1.3.Нягтлан бодох бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хөтлөх ажлыг зохион байгуулах;

19.1.4.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргаж, эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх холбогдох байгууллагад хүргүүлэх;

19.1.5.Холбооны гишүүдийн бүртгэлийг хөтлөх ажлыг зохион байгуулах;

19.1.6.Холбооны дүрэмд заасан бусад.

19.2.Гүйцэтгэх удирдлагын цалин хөлсийг удирдах зөвлөлийн хурлаас тогтооно.

## **20 дугаар зүйл.Хяналтын хороо**

20.1.Удирдах зөвлөлөөс Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын хороог байгуулна.

20.2.Хяналтын хорооны гишүүдийг удирдах зөвлөлөөс томилох бөгөөд бүрэлдэхүүнд гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх албан тушаалтнаас оролцуулахыг хориглоно.

20.3.Шаардлагатай тохиолдолд Холбооны үйл ажиллагаанд аудит хийлгэх саналыг удирдах зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

20.4.Хяналтын хороо ажлаа удирдах зөвлөлийн өмнө тайлагнана.

20.5.Хяналтын хороог мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэх удирдлага хариуцна.

20.6.Хяналтын хорооны үйл ажиллагааны зардал, гишүүдэд олгох урамшууллыг удирдах зөвлөлөөс тогтооно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **21 дүгээр зүйл.Зөвлөлийн бүрэн эрх**

21.1.Зөвлөл нь бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.бооцоот морин уралдааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

21.1.2.оролцогч, унаач, уяачаас цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

21.1.3.Холбооноос шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;

21.1.4.Холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, морин тойруулгын цогцолборын тоног төхөөрөмжийг шалгах, магадлагаа хийх;

21.1.5.энэ хуульд заасан үүргийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;

21.1.6.Холбооны удирдлага, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах арга хэмжээ авах.

21.2.Бооцоот уралдаанд оролцогчийн тавьж болох бооцооны дээд хэмжээг Зөвлөл батална.

21.3.Бооцоот уралдааны мөнгөн кассын өрөөнд тавигдах шаардлагыг Зөвлөл батална.

### **22 дугаар зүйл.Бооцоот уралдааны үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт**

22.1.Зөвлөлийн ажлын алба бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, эсхүл гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.

22.2.Уралдаан зохион байгуулах үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирсэн тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд Холбоонд хүргүүлсэн хугацаатай албан шаардлагын биелэлтийг шалгах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.

22.3.Улсын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.3.1.бооцоот морин уралдааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

22.3.2.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

22.3.3.хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох, хяналт шалгалтын явцад зөрчлийн ул мөр, нотлох баримт цуглуулах, зөрчлийн талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор шалгагдаж байгаа этгээдийн бие, албан тасалгаа, бичиг баримт, компьютер, эд зүйлд үзлэг хийх, шаардлагатай баримт материал, эд зүйлийг түр хураан авах;

22.3.4.бооцоот уралдааны үйл ажиллагааны явцын хяналтын дуу, дүрс, бичлэгийг шалгах;

22.3.5.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **23 дугаар зүйл.Бооцоот морин уралдааны хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

**1 дүгээр зүйл.**Бооцоот морин уралдааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор Монголын морин уралдааны холбооны Бүх гишүүдийн хурлыг хуралдуулна.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан Бүх гишүүдийн хурлыг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл зохион байгуулна.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Бооцоот морин уралдааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн хуульд доор дурдсан агуулга бүхий 5.22 дугаар зүйл нэмсүгэй:

#### **“5.22 дугаар зүйл.Бооцоот морин уралдааны тухай хууль зөрчих**

1.Холбоо Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулаагүй бол хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Морин тойруулгын цогцолборт мөнгөн зээлийн үйл ажиллагаа, банк, эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийн хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Бооцоот морин уралдаанд 18 насанд хүрээгүй хүнийг оролцуулсан, эсхүл 18 насанд хүрээгүй унаачийг уралдуулсан бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Холбоо, эсхүл дотоод мэдээлэл эзэмшигч оролцогчоор дамжуулан мөрий тавьсан, тоглогчийн мөрийний тухай шийдвэрт дотоод мэдээллийг ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Уралдаанд оролцогчийг зээлээр оролцуулсан бол хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Холбоо бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Холбоо Зөвлөлийн баталсан бооцооны хэмжээнээс илүү хэмжээгээр оролцогчоос бооцоо хүлээн авсан, эсхүл морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог хуваарилах дүрэм, бооцоот уралдааны мөнгөн кассын дүрэм, аргачлалыг мөрдөөгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Бооцоот морин уралдааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

## Агуулга

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хоёр. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

- 2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал
- 2.2 Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- 2.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд
- 2.4 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Гурав. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судалсан нь

Тав. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

5. 1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
5. 2 Нийгэмд үзүүлэх үр нөлөө
5. 3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
5. 4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
5. 5 Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх

Зургаа. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судалсан байдал

Долоо. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Найм. Дүгнэлт, Зөвлөмж

## **Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан**

### **НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу бооцоот морин уралдааны талаарх асуудалд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх тандан судалгааг хийв.

Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд монгол адууг хассан талаар, эрлийз адууг уралдуулсан, хассантай холбоотой маргаан жил бүр их гарч байна. Одоо мөрдөж байгаа хууль, дүрэм журамд монгол эрлийз морьдыг сэрвээний өндрөөс гадна үүлдэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялган уралдаанаас хасаж, олон зуун уяачдын дунд маргаан үүсгэж, нөгөөтэйгүүр тэдний хөдөлмөрийг үнэгүйдүүлсээр байна.

Түүнчлэн хаврын морин уралдааныг хориглосон боловч зөвшөөрөлгүйгээр морин уралдаан зохион байгуулж, бооцоо тавих, үүнийг дагаж унаач хүүхдийн эрхийн асуудал хөндөгдсөөр ирсэн тул морин уралдааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан судлах шаардлагатай болжээ.

---

<sup>1</sup>“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

## ХОЁР. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

### 2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

1. Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон боловч үүний дагуу дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох үйл ажиллагаа төдийлөн бүрэн хангагдаагүй буюу эдгээр хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоо байхгүй байна.

Хүүхдээр хурдан морь унуулснаар тэдний амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах ашиг сонирхлыг ноцтой зөрчдөг 1996-2006 онд 17 хүүхэд, 2006-2008 онд 2 хүүхэд, 2012-2014 онд 6 хүүхэд хурдан мориноосоо унаж амь насаа алдсан байх бөгөөд бусад оны мэдээлэл олдохгүй байна. Энэ мэдээллээс харахад доод тал нь 25 унаач хүүхэд амь насаа алдаад байгаа бөгөөд жил бүр дунджаар хоёр хүүхэд мориноос унасны улмаас амиа алддаг байна.<sup>2</sup>

Мориноос унаж амь насаа алдах нь хаврын төдийгүй зуны уралдааны үед ч элбэг тохиолддог. 1996-2006 онд 17 хүүхэд хурдан морины уралдааны явцад мориноосоо унаж амь эрсэдснээс 6 нь зун (намар), 2 нь хавар (өвөл) тохиолдсон байх бөгөөд үлдсэн 9 тохиолдол хэзээ болсон нь тодорхойгүй. 2007 оны 7 дугаар сарын эхээр Сонгинохайрхан дүүргийн Өлзийт хороололд болсон уралдааны үеэр 12 настай хүүхэд мориноосоо унаж тархины хүнд гэмтэл авч эрсэдсэн харамсмаар баримтууд цөөн биш байна.<sup>3</sup>

Түүнчлэн 2012-2014 онд жилд дунджаар 300-320 унаач хүүхэд мориноос унаж бэртсэн, түүнээс 180-220 хүүхэд нь хүнд хэлбэрийн бэртэл авч, эмнэлэгт хэвтсэн<sup>4</sup>, 2022 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр Архангай аймгийн Ихтамир сумын Элстэй гэх газар хурдан морины уралдаанд бэлдэж байсан 12 настай эрэгтэй уралдаанч хүүхэд мөсөн дээр унаж, моринд өшиглүүлэн дунд чөмгөө хугалжээ.<sup>5</sup>

Хүний эрхийн үндэсний комисс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран 2015 онд “Хаврын хурдан морины уралдаан дахь хүүхдийн эрх” судалгааны зөвлөмжид Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс хурдан морь унахад тохиромжтой бие бялдар, нас, оюун ухааны хувьд өөрийн болоод бусдын үйлдлийг ойлгох, өөрт үүсч болох эрсдэлийг бүрэн ойлгож, ухаарах насанд хүрсэн үед нь хаврын хурдан морины уралдаанд оролцуулах, өөрөөр хэлбэл 18 наснаас дээш насныхан уралддаг хүйтний улирлын морины уралдааны шинэ төрлийн спорт, түүний эрх зүйн зохицуулалтыг

---

<sup>2</sup> Хууль зүйн профессор О.Мөнхсайхан “Хурдан мориноос унаж амь насаа алдсан 25 хүүхдийн гэгээн дурсгалд зориулав” [https://www.trends.mn/n/6169#\\_ftnref4](https://www.trends.mn/n/6169#_ftnref4)

<sup>3</sup> Мөн тэнд.

<sup>4</sup> Э.Номин-Эрдэнэ, “Жилд 300 гаруй хүүхэд мориноос унаж эмнэлэгт ханддаг,” Өдрийн Сонин, 2015.10.21, <https://dnn.mn/>

<sup>5</sup> Б.Од “Зөвшөөрөлгүй хурдан морины уралдааны үеэр 12 настай хүүхэд унаж бэртжээ”, Зууны мэдээ сонин, 2022.02.09, <https://www.zms.mn/a/88379>

бий болгох, Хурдан морины уралдаан зохион байгуулдаг, хянадаг нийтийн эрх зүйн этгээд бий болгох зөвлөмжүүдийг тусгасан байна.

2.Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд монгол адууг хассан талаар, эрлийз адууг уралдуулсан, хассантай холбоотой маргаан жил бүр гарсаар байна.

Одоо мөрдөж байгаа хууль, журам, дүрэмд монгол эрлийз морьдыг сэрвээний өндрөөс гадна үүлдэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялган уралдаанд оролцуулах эсэхийг шийддэг байна.

Гэвч сэрвээний өндөр, монгол морины үүлдэрлэг байдал зэргийн алийг нь үндэслэн морьдыг хурдан морины уралдааны бүртгэлд бүртгээгүй, уралдуулахаас хассан зэрэг нь тодорхойгүй, ил тод байдаггүйгээс уг асуудал маргаан дагуулж, олон зуун уяачдын хөдөлмөрийг үнэгүйдүүлдэг байна.

3.Үндэсний статистикийн газрын тоон мэдээллээс харахад 2019 онд Монгол Улсад 577.3<sup>6</sup> мянган гадаадын иргэн аялал жуулчлалын зорилгоор ирсэн бол Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор 2020 онд энэ тоо 58.9<sup>7</sup> мянга болж өмнөх оны энэ үеэс даруй 90 орчим хувиар, 2021 онд 33.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 43.8%-р тус тус буусан байна.

Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан.

Монгол Улсад ирсэн нийт жуулчдын 70 орчим хувь нь II, III дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирсэн Олон жилийн дунджаас үзвэл долдугаар сард Монгол Улсад зочлох жуулчдын тоо харьцангуй нэмэгддэг бөгөөд ойролцоогоор 100 орчим мянган жуулчин ирдгээс дийлэнх жуулчин Улаанбаатарт наадам үзэхээс гадна аймаг орон нутгийн хуваарийн дагуу хөдөөд очиж наадам үздэг<sup>1</sup> байна. Мөн жил бүр 10 мянган орчим жуулчин наадмын нээлт үзэхээр захиалга өгдөг байна.

Эдгээр тоон мэдээллээс үзэхэд Монгол Улсад ирж буй жуулчдын дийлэнх нь Монголын соёлын өв болох Монгол наадам, эрийн гурван наадам (бөх, хурдан морины уралдаан, сурын харваа багтана) үзэхээр зорин ирдэг бөгөөд нөгөөтэйгүүр манай орны цаг уурын байдал болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэрэг нь өвлийн улиралд ирэх жуулчдын тоонд нөлөөлдөг байна.

Иймд уг судалгаагаар унаач хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр өв соёл, түүхэн уламжлалаа тээж үлдэх, түүгээрээ дамжуулан жуулчдыг татах, Олон Улсын

<sup>6</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 оны 2 дугаар сар.

<sup>7</sup> мөн тэнд



жишигт нийцсэн морин тойруулгад бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, асуудлыг хөндөх болно.

## 2.2 Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдал

1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "баяр наадмын хурдан мориог 7-гоос дээш насны хүүхдэд" унахыг зөвшөөрчээ. Засгийн газрын 2005 оны 119-р тогтоолоор батлагдсан "Хурдан морины уралдааны дүрэм"-ээр унаач хүүхдүүд нь 7-гоос дээш настай байхаар заасан. Гэвч, энэ дүрэм зөвхөн Үндэсний их баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулж буй морин уралдаанд хамаардаг бөгөөд бусад морин уралдаанд насны хязгаар байхгүй байна.

Биеийн тамир спортын тухай (2003) хуулийн 3.1.5-д заасан заалтаар Хурдан морины уралдаанч хүүхдийг тамирчин1 гэсэн ойлголтод хамруулж болно гэж үзэх тал байгаа боловч эрт дээр үеэсээ Монгол үндэстний уламжлан наадаж ирсэн эрийн гурван наадмыг спортын төрөл мөн эсэх асуудал дээр судлаачид бас өөр өөр байр суурьтай байдаг учир Хурдан морины уралдаанч хүүхдийг тамирчин гэж үзэх асуудал ч эргэлзээтэй байдаг.

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолоор Үндэсний морин уралдааны морины уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага буюу MNS 6264:2011 заавал мөрдөх стандарт баталж, Хурдан морины уралдаанч хүүхдийн уралдаан болон бэлтгэл сургуулилтын үед өмсөх малгай, нүдний шил, цээживч, өвдгөвч, тохойвч, гутал, эмээл, хазаар, ташуурт тавих шаардлагыг тогтоосон байна.

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Хурдан морины уралдааныг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн насны ангиллаар зохион байгуулна" гэж заасан бөгөөд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 34 дүгээр тогтоолоор Хурдан моринд тавих ерөнхий шаардлага буюу MNS6464:2014 стандартад хурдан морины сэрвээний өндрийн дээд хэмжээг тогтоож, Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын "Их Хурд" уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаан зохион байгуулахад хамаарахаар заажээ.

Мөн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/49 дүгээр тушаалаар Монгол үүлдэр, омгийн адуу стандарт/MNS4099:2010/-аар Монгол морьдын үүлдэрлэг байдал буюу гадаад шинжийг нь тогтоосон байна.

### 1. Хурдан моринд тавих ерөнхий шаардлага MNS6464 2014

	Нас	Сэрвээний өндрийн хэмжээ, см
1	Даага	129
2	Шүдлэн	134
3	Хязаалан	138
4	Соёолон	141
5	Их нас	143
6	Азарга	141

## 2.Монгол үүлдэр, омгийн адуу MNS 4099 2020

### Цөм сүргийн адууны үндсэн хэмжээ

	Нас	Сэрвээний өндрийн хэмжээ, см
1	Даага	125
2	Шүдлэн	128
3	Хязаалан	130
4	Соёолон	137
5	<b>Их нас</b>	
6	Азарга	139

Энэ стандартад их насны морины сэрвээний өндрийг тогтоож өгөөгүй болно.

3.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний их баяр наадмаар хурдан морь уралдуулах журам”

	Нас	Сэрвээний өндрийн хэмжээ, см
1	Азарга, Соёолон	140
2	Их нас	141
3	Хязаалан	137
4	Шүдлэн	132
5	Даага	127

Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын “Их Хурд” уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаанд дээрх стандартад нийцсэн адууг уралдуулах зохицуулалттай бөгөөд Монгол эрлийз морьдыг сэрвээний өндөр, үүлдэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялган хурдан морины уралдаанаас хасах эсхүл уралдуулах зэрэг нь маргаан дагуулсаар иржээ.

Мөн сэрвээний өндөр, монгол морины үүлдэрлэг байдал зэргийн алийг нь үндэслэн морьдыг хурдан морины уралдааны бүртгэлд бүртгээгүй, уралдуулахаас хассан зэрэг нь тодорхойгүй, ил тод байдаггүй зэрэг нь олон зуун уяачдын хөдөлмөрийг үнэгүйдүүлж байна гэж үзэхээр байна.

Ийнхүү хурдан унаач хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр өв соёл, түүхэн уламжлалаа тээж үлдэх шаардлага зайлшгүй тулгарч байгаагаас гадна хурдан морь эзэмшигч, уяачдад жилийн аль ч улиралд морио уралдуулах, Улсын наадамд уралддаггүй морио уралдуулах бололцоог бий болгох, Олон Улсын жишигт нийцсэн морин тойруулга байгуулах бооцоот морин уралдааны эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

### 2.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Хүснэгт 1

№	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
---	-----------------------------	--------------------

1	Уяач	Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд монгол адууг хассан талаар, эрлийз адууг уралдуулсан, хассантай холбоотой маргаан жил бүр их гарч байна. Одоо мөрдөж байгаа хууль, дүрэм журамд монгол эрлийз морьдыг сэрвээний өндрөөс гадна үйлдвэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялган уралдаанаас хасаж, олон зуун уяачдын хөдөлмөрийг үнэгүйдүүлж байна.
2	Унаач	Хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах ашиг сонирхол ноцтой зөрчигддөг.

#### 2.4 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Монгол Улсад бооцоот морин уралдааны үйл ажиллагаатай холбоотой шийдлээ хүлээж буй хэд хэдэн асуудал байсаар байна. Үүнийг үүсгэж буй учир шалтгааныг багцлан үзвэл:

- 1) Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд тавигдах стандарт байхгүйн улмаас зөвшөөрөлгүй уралдаан зохион байгуулж, унаач хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсаар байна.
- 2) Монгол соёлын өв болох морин уралдааныг зөвхөн үндэсний их баяр наадмын уралдаанаар хязгаарлаж байгаа нь уяачдын ажил, хөдөлмөрийг үнэгүйдүүлдэг.
- 3) Бооцоот морин уралдааны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт байхгүй.

Дээрхээс дүгнэж үзвэл асуудлыг үүсгэж буй шалтгаан нь тодорхой байх тул бооцоот морин уралдааны үйл ажиллагааны зохицуулалтыг судлах, бий болгох, бооцоот морин уралдаанд тавигдах стандартыг бий болгох, хурдан морийг 18 насанд хүрсэн мэргэжлийн унаачаар унуулах, жилийн аль ч улиралд уралдаан зохион байгуулах боломжит морин тойруулга байгуулснаар хууль ёсоор бооцоот морин уралдаан зохион байгуулах нөхцөл бүрдэж, унаач, уяач, морин уралдаан сонирхогчдын эрхийг хангах нөхцөл бүрдэнэ.

#### **ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Аргачлалд заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна.

**Зорилго:** “Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, хяналт тавих”

#### **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 3-т заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, хяналт тавих” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 2

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг.
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	<b>Тодорхой үр дүнд хүрнэ.</b>
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Татварын бодлогоор хязгаарлалт тавьж болох ч эрх зүйн зохицуулалтыг бий болгоогүй тохиолдолд зорилгыг бүрэн хангаж чадахгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх нь тухайн зохицуулахыг зорьж буй харилцаанд тохиромжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллагад тодорхой чиг үүргийг шилжүүлэх нь асуудлыг цогц байдлаар шийдэх шийдэл биш.	Тодорхой хэмжээний зардал гарах бөгөөд асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	<b>Тодорхой үр дүнд хүрнэ.</b>
6	Захиргааны шийдвэр гаргах	Оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэх боловч үр дүнд төдийлөн ахиц гарч чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	<b>Тодорхой үр дүнд хүрнэ.</b>
	Хууль тогтоомжийн	Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх тусгай	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол	<b>Үр дүнтэй.</b>

	төсөл боловсруулах	зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, хяналтыг бий болгож, тус харилцаанд оролцож буй талуудын эрх ашгийг тэгш байдлаар хангагдана.	шалтгаануудыг цогцоор нь шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	
--	--------------------	--	--	--

- 1) Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах энэхүү хувилбар нь одоо байгаа эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээнэ гэсэн үг. Хэрэв одоогийн байгаа зохицуулалтыг хэвээр үлдээвэл бооцоот морин уралдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож чадахгүйн дээр өнөөдөр нийгэмд үүсээд буй асуудлууд цаашид хэвээр үргэлжилж, сөрөг үр дагавар нь улам нэмэгдэнэ.
- 2) Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд олон нийтийн зүгээс анхаарах асуудал зэргийг таниулах нь бусад хувилбартай харьцуулахад олон нийтийн хяналтыг сайжруулах, шүүх хурдтай ажиллахад нөлөөлөх, зардал бага гарах зэрэг эерэг нөлөөтэй боловч дэвшүүлсэн зорилгыг дангаараа хангах боломжгүй байна.
- 3) Төрийн зүгээс татварын бодлогын хүрээнд зорилгод заасан хэмжээнд зохицуулах нь өнөөдрийн түвшинд боломжгүй байна.
- 4) Төрөөс санхүүгийн интервенци хийх буюу тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлэх хувилбар нь тохиромжгүй байна.
- 5) Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх нь тодорхой үр дүнд хүрэх хэдий ч асуудлыг цогцоор нь шийдэх хувилбар биш юм.
- 6) Захиргааны шийдвэр гаргах замаар зорилгыг хангахад тодорхой үр дүнд хүрэх хэдий ч өнөөдрийн байдлаар захиргааны шийдвэр гаргах боломжгүй байна. Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд бооцоот морин уралдаантай холбоотой захиргааны шийдвэр гаргах эрхийг аль нэг төрийн байгууллагад өгөөгүй тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй юм.
- 7) Хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь бооцоот морин уралдааныг олон улсын жишигт нийцсэн морин тойруулгад зохион байгуулах, түүгээрээ дамжуулан жуулчид татах, соёлын өв болох хурдан морийг дэлхийд сурталчлах, хурдан морийг мэргэжлийн унаач/жокейчин/ унаж уралдсанаар,

унаач хүүхдийн эрх зөрчигдөхгүй байх нөхцөл бүрдэж, түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулах бизнесийг дэмжих, гэх зэрэг нийгэмд үүсээд буй асуудлуудыг шийдэх боломжтой гэж үзлээ.

Дээрх харьцуулалтаас харахад дараах хувилбар илүү эерэг нөлөөтэй байх магадлалтай байна.

**Хувилбар:** Бооцоот морин уралдааны үйл ажиллагааг тусдаа бие даасан хуулиар зохицуулах. Тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна.

Тус хуулиар *“бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг”* зохицуулна.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 4-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасан шалгуур асуултын дагуу тандан судалсан байдлыг хүснэгт 3,4,5,6-аас үзнэ үү.

### **5.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Боловсруулсан хувилбарын хүрээнд Бооцоот морин уралдааны үйл ажиллагааг тусдаа бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзсэн. Хурдан морины бооцоот уралдаантай холбоотойгоор унаач хүүхдийн эрх ноцтой зөрчигдсөөр байна.

Монгол Улсын Үндсэн хуульд насанд хүрээгүй хүмүүсийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлын үндсийг тусгайлан хуульчлаагүй хэдий ч иргэдийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлыг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт тулгуурлан тогтоодог. Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцийн оролцогч болсон бөгөөд холбогдох үндэсний хууль тогтоомжийг конвенцийн шаардлагад нийцүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд бооцоот морин уралдааныг олон улсын стандартад нийцсэн морин тойруулгад зохион байгуулах эрх зүйн үндсийг бий болгосноор зөвшөөрөлгүй бооцоот морин уралдаан зохион байгуулснаас үүсэх хүүхдийн эрхийн зөрчил арилж, хүний эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

### **5.2 Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Сонгосон хувилбарын хувьд бооцоот морин уралдааны үйл ажиллагаатай холбоотой нийгэмд тулгамдаж буй олон асуудалд эерэг өөрчлөлт авчрана гэж үзлээ.

### **5.3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Тухайн харилцааг зохицуулсан бие даасан хууль батлах нь тодорхой хэмжээнд зардал гарах боловч эдийн засаг, бизнесийн хувьд эерэг нөлөө үзүүлнэ.

#### 5.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Доорх хүснэгтүүдэд нарийвчилсан мэдээллүүдийг харуулъя.

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахыг хориглосон зохицуулалт байхгүй байдлаар эрх зүйн харилцааг зохицуулна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн аль нэг бүлэг, нэгж, хэсэгт давуу эрх олгохгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Бие даасан хууль батлах нь түр тусгай арга хэмжээ биш.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж	Тийм	Үгүй	

	болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх			
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүүхдийн үндсэн эрхийн хэрэгжилт сайжирна.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцсэн байна.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгана.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт байхгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг	Тийм	Үгүй	



	бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллага, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлно.
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг үр нөлөө агуулаагүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг үр нөлөө агуулаагүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс	Тийм	Үгүй	Хуулийн хязгаарлалтуудаар бий болгоно.

	хамгаалахад нөлөөлж чадах эсэх			
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Хуулиар тодорхойлсон шаардлагыг биелүүлэхтэй холбоотой зардал үүснэ.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл үүсгэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зөвшөөрөл авах, тайлагнах, мэдээлэх үүргийг хуулиар ногдуулах тул тодорхой захиргааны зардал гарна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус	Тийм	Үгүй	

	баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх			
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг дэлгэрэнгүй зохицуулна.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Бооцоот морин тойруулгыг дагасан үйлчилгээний салбарт ажлын байрыг шинээр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.

	нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх			
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд татвар ногдуулснаар улсын төсөвт татврын орлого нэмэгдүүлнэ. төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Мөрийтэй тоглоомын хяналтын зөвлөл байгуулагдах хэдий ч агентлагийн статустай биш болно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Мөрийтэй тоглоомын хяналтын зөвлөл хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Зээлийн хүү буурахад нөлөө үзүүлэх тул шууд бусаар инфляци буурахад нөлөөтэй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагаа эрхлэх бизнес эрхлэх боломж, үүнийг дагаад шинэ ажлын байр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Бооцоот морин уралдааны үйл ажиллагааны стандарт бий болно.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Бооцоот морин уралдааны оролцогчдод тавигдах стандартыг тогтооно.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.

хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зөвшөөрөл олгох болон хяналт тавих.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөл байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Соёл	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

### БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 6

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруул ах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.



	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

#### 5.5 Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11-т "хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж 10-р зүйлийн 2-т "Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ" гэж, заасан бөгөөд 1990 оны Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцын 6-р зүйлд "Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана," 24-р зүйлд "Оролцогч улсууд хүүхдийн эрүүл мэндийг хохироох уламжлалт дадлыг устгах зорилгоор үр нөлөөтэй, зохистой бүх арга хэмжээг авна" гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Оршилд Монголын ард түмэн бид "төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх" тухай тунхагласан.

Бооцоот морин уралдааны тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх буюу Соёлын тухай хуулиар зохицуулах харилцааг конвенцид заасны дагуу илүү өргөн хүрээнд авч үзэх нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

## **ЗУРГАА.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалд зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал
- Зардал, үр өгөөжийн харьцаа
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр дахин нягтлан үзээд дараах дүгнэлтийг хийлээ.

Захиргааны шийдвэр гаргах зохицуулалтын хувилбар нь гарах зардлын хувьд бие даасан хууль батлан гаргахаас бага зардалтай хэдий ч зорилгод хүрэх боломжгүй байна. Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд бооцоот морин уралдааны үйл ажиллагаатай холбоотой захиргааны шийдвэр гаргах эрхийг аль нэг төрийн байгууллагад өгөөгүй тул энэ хувилбарыг хэрэгжүүлж зорилгод хүрэх боломжгүй болох нь харагдаж байна.

Харин Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь захиргааны шийдвэр гаргах зохицуулалтын хувилбараас илүү зардал гарах хэдий ч үр өгөөжийн хувьд зорилгод хүрэх боломжтой байна.

Учир нь бооцоот морин уралдааныг олон улсын жишигт нийцсэн морин тойруулгад зохион байгуулах, түүгээрээ дамжуулан жуулчид татах, соёлын өв болох хурдан морийг дэлхийд сурталчлах, хурдан морийг мэргэжлийн унаач/жокейчин/ унаж уралдсанаар, унаач хүүхдийн эрх зөрчигдөхгүй байх нөхцөл бүрдэж, түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулах бизнесийг дэмжих, гэх зэрэг нийгэмд үүсээд буй асуудлуудыг шийдэх боломжийг бий болгож өгснөөрөө хүний эрх, эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх боломжтой талаар судалгааны өмнөх хэсгүүдэд дурдсан болно.

Иймд дээрх хоёр хувилбараас орчин үеийн чиг хандлага болон гадаад орнуудын зохицуулалтыг харьцуулан үзэхэд бооцоот морин уралдааны үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулах нь илүү үр өгөөжтэй гэж үзлээ.

## **ДОЛОО. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Харьцуулсан судалгаанд бооцоот морин уралдааны талаарх олон улсын хэмжээнд илүү сайн, жишиг болохуйц туршлагаар зохицуулж буй Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британийн Нэгдсэн Вант Улс болон Хонг Конгийн хууль тогтоомжийг сонгон авч судаллаа.

Бооцоот морин уралдаан нь дэлхийн олон улсад тодорхой хяналттайгаар, тусгайлсан нэмэгдэл татвартайгаар эрхлэхийг зөвшөөрдөг мөрийтэй тоглоомын төрөл бөгөөд улс бүрийн онцлогоос хамаараад олон загвартай байж болдог байна. Гэхдээ бооцоот морин уралдааны загварыг ерөнхийд нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус загвар гэж 2 хувааж болохоор байна.

## **1.Ашгийн төлөө бус загвар**

Тухайлбал Хонг Конгийн Жокэй Клуб нь ойролцоогоор 135 жилийн түүхтэй ашгийн төлөө бус байгууллага бөгөөд Хонг Конгод монополь эрхтэйгээр бооцоот морин уралдаан зохион байгуулдаг. 7 хоногийн 2 өдөр морин уралдаан зохион байгуулах бөгөөд бооцооноос цугласан орлогоос бооцоо тавигчдад буцаан өгсөн дүнг хассаны дараах дүнгийн 72,5 хувийг татварт төлдөг байна.<sup>8</sup> (Харин бооцооны хожлоос ХХОАТ авдаггүй)

Хүн амын тоо олон, нэг л байгууллага монополь эрхтэйгээр үйл ажиллагаа явуулдаг, бусад төрлийн бооцоотой, мөрийтэй тоглоом хууль бус байдаг зэргээс шалтгаалан морин уралдаан үзэгч, бооцоот уралдаанаас олох орлого нь жилээс жилд буурахгүй, харин өсөх хандлагатай байдгаараа онцлог байна. Түүнчлэн Клуб нь 4 төрлийн гишүүнчлэлтэй бөгөөд гишүүнчлэлийг олгох шалгуур нь өндөр тул энэ нь тухайн хүний нийгэм дэх байр суурь, нэр хүндийн илэрхийлэл болдог нь мөн нөлөөлдөг байна.

Мөн БНСУ-д Солонгосын уралдааны газар (*Korea Racing Authority*) гэж бооцоот морин уралдаан зохион байгуулах эрхтэй ганц байгууллага байх бөгөөд тус байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг (public company). Тус газар Сөүл, Бусан, Жежү-д байрлалтай 3 морин тойруулга эзэмшдэг.

Солонгосын уралдааны газар нь олон нийтийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Солонгосын адууны үүлдэрийг сайжруулах, морин спортын салбарыг хөгжүүлэх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлдэг:

- Бооцоот морин уралдаан;
- Хурдан морины уралдаантай төстэй бусад төрлийн амьтны уралдаан зохион байгуулах;
- Адуу үржүүлэх, сурталчлах, ашиглах, сургах;
- Морин уралдааны талбайд энгийн спорт, амралт зугаалгын байгууламжуудыг байгуулж ажиллуулах;
- Загасчид, тариачдын хүүхдүүдэд тэтгэлэг олгох;
- Загас агнуурын болон газар тариалангийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх.

Тус улсад букмэйкэр эсвэл хувийн мөрийтэй тоглоомын операторуудын бүх үйл ажиллагааг хуулиар хориглодог. Зөвшөөрөгдөх бооцооны хэмжээ нь нэг удаагийн бооцоонд 100-100,000 вон байдаг.

<sup>8</sup> <https://www.ird.gov.hk/eng/tax/bdu.htm>

Морин бооцооны зургаан төрлийг санал болгодог бөгөөд төрлөөс үл хамааран 16% татвартай байна.

	WIN	PLACE	QUINELLA	EXACTA	QUINELLA PLACE	TRIO
DIVIDEND	80%	80%	73%	73%	73%	73%
TAX	16%	16%	16%	16%	16%	16%
RETURN TO KRA	4%	4%	11%	11%	11%	11%

Бооцооны 73-80%-ийг бооцоо тавигчдын ашигт буцааж өгдөг. Харин үлдсэн 27% нь:

-Татвар (16%), үүнд:

амралт чөлөөт цагийн татвар (leisure tax) (10%),  
орон нутгийн боловсролын татвар (4%),  
хөдөөгийн хөгжлийн тусгай татвар (2%).

-Тодорхой зориулалт болон морины салбарт хөрөнгө оруулалт хийх зориулалт бүхий нөөц сан (4%),

-Морин уралдааны үйл ажиллагааны ерөнхий зардал (7%) байдаг байна.<sup>9</sup>

Монгол Улсад хэрэв ашгийн төлөө бус загварыг сонгох бол сонгон шалгаруулалтад тавигдах нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд уяачдын холбоо зэрэг төрийн бус байгууллагад бооцоот морин уралдаан зохион байгуулах эрхийг олгож болох юм.

Тухайлбал, зөвшөөрлийг төсөл сонгон шалгаруулах замаар олгох тул морин тойруулга барихаар санал болгож байгаа зураг төсөл, хөрөнгө оруулалтын хэмжээ, зөвшөөрөл хүсэгчийн нийгэмд болон мэргэжлийн хүрээлэлдээ хүлээн зөвшөөрөгдөж байгаа байдал зэргийг харгалзан өрсөлдүүлж, хамгийн тохиромжтойг нь сонгож зөвшөөрөл олгох боломжтой.

Ашгийн төлөө бус загварын онцлог нь:

-Гишүүддээ ногдол ашиг тараахгүй, татан буугдах тохиолдолд хөрөнгийг нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллагад шилжүүлнэ;

-Ашгийн төлөө үйл ажиллагаа нь байгууллагын үндсэн зорилго, үйл ажиллагаа байх нь хориотой тул эрхлэх үйл ажиллагааны 50 хувиас доошгүйг дүрэмд заасан нийгмийн сайн сайхны төлөөх ашгийн бус үйл ажиллагаа эзлэх шаардлагатай;

-Монополь байдлаар үйл ажиллагаа явуулах тул өрсөлдөөн бага;

-Бооцоот морин уралдааныг ашиг олох бизнесийн үйл ажиллагаа гэж үзэхээс илүүтэйгээр морин спортыг сурталчлах, олон нийтэд таниулах, иргэд амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд ач холбогдолтой үйл ажиллагаа гэдэг үүднээс хандах давуу талтай.

## 2. Ашгийн төлөө загвар

<sup>9</sup> <https://www.kra.co.kr/globalEn/koreaRacingAuthority.do>

Их Британи Улсад 59 морин тойруулга байгаа бөгөөд эдгээрийн 30 нь 2 компанийн өмчид, үлдсэн 29 нь дан дангаараа хувийн эзэмшилд байдаг байна.

Морин уралдааны бооцоог зохион байгуулж байгаа этгээд нь ямар схемээр бооцоо тавиулж байгаагаасаа шалтгаалаад букмэйкэр нь бооцооноос төвлөрсөн орлогоос бооцоо тавигчдад буцаан олгосон дүнг хассан дүнгийн 15%-30% хувиар татвар төлөх үүрэгтэй байна.<sup>10</sup>

АНУ-нийт 112 морин тойруулга байдаг бөгөөд эдгээрийн ихэнх нь хувийн эзэмшилд байдаг бөгөөд морь, унаач, морь сургагч зэрэг бүх ажилтнуудыг гэрээний үндсэн дээр авч ажиллуулах бөгөөд ашиг олох зорилготой бизнесийн үйл ажиллагаа гэж үзэх тул бизнесийн орчин нь ашгийн төлөө бус загваруудыг бодвол харьцангуй чөлөөтэй байдаг. Бооцоо тавих схемээс болон үйл ажиллагаа явуулж байгаа мужуудаас хамаараад татварын хэмжээ нь ондоо байх боловч ойролцоогоор татвар нь 20 хувь (гэхдээ бооцооноос бүрдсэн хожлын сангийн дүнд ногдуулна) байдаг байна. (Бооцоо тавигч нь тавьсан бооцоогоо 300-аас дээш хувиар өсгөж хожсон бол хожлын дүнгийн 24%-иар ХХОАТ төлнө.)<sup>11</sup>

Ашгийн төлөө загварын онцлог нь:

-Ашгийн төлөө компани тул хувьцаа эзэмшигчид нь ногдол ашиг хүртэж, татан буугдах бол хөрөнгөө хувааж авна;

-Татвараа шударгаар төлсөн тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч нь олсон орлогоо өөрийн үзэмжээр зарцуулна;

-Монополь зах зээл биш тул хэд хэдэн этгээдүүд хоорондоо өрсөлдөнө;

-Ашгийн төлөө үйл ажиллагаа тул олон нийтийг бооцоот тоглоомонд донтуулах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаагаа ёс зүйгүй явуулах магадлалтай тул энэ талаар зохицуулалт, хоригууд тавих шаардлагатай болох магадлалтай.

Мөн зарим улс орнуудыг буюу Их Британи, Сингапур, Дани, Кени, Япон, Шинэзеланд зэрэг улсуудыг судалж үзэхэд хурдан морины бооцоот уралдааны асуудлыг бие даасан хуулиар зохицуулаагүй бөгөөд “Бооцоот тоглоомын тухай” гэдэг ерөнхий зохицуулалтын доор казино, лоттерей, бинго, сугалаа, тоглоомын машин ажиллуулах, хурдан морины болон нохой, бусад амьтны бооцоот уралдааныг зохион байгуулахтай холбоотой харилцааг нэгтгэн зохицуулж байна. Ийнхүү бооцоот тоглоомтой асуудлыг нэгтгэн зохицуулахдаа нэр томъёоны тайлбарыг нарийвчлан тусгаж, тоглоом тус бүрт хамаарах тусгай зөвшөөрлийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын талаар хуулинд тусгаж, хүлээлгэх хариуцлагыг нэг бүрчлэн тодорхойлжээ.

<sup>10</sup> <https://www.gov.uk/guidance/general-betting-duty-pool-betting-duty-and-remote-gaming-duty>

<sup>11</sup> <https://turbotax.intuit.com/tax-tips/jobs-and-career/how-to-pay-taxes-on-gambling-winnings-and-losses/L7JNH7min>

## НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### Зөвлөмж

Ийнхүү Монгол үндэстний дэлхийд бахархах өв соёл болох Монгол наадмын морин уралдааны харилцааг хөндөхгүйгээр 18 наснаас дээш насныхан уралддаг бүх улирлын морины уралдааны шинэ төрлийн спорт, түүний эрх зүйн зохицуулалтыг бий болгож, олон улсад хэрэгжүүлж буй эрх зүйн зохицуулалтын сайн туршлагаас Монгол Улсад нутагшуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь унаач хүүхдийн эрхийг хамгаалах, соёлын өв болох хурдан морийг дэлхийд сурталчлах, түүгээрээ дамжуулан жуулчид татах, түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулах бизнесийг дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын Бооцоот морин уралдааны тухай хууль тогтоомжид тусгасан нийтлэг буюу жишиг зохицуулалтыг тодорхойлсны үндсэн дээр Монгол Улсын бооцоот морин уралдааны үйл ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох талаар дараах санал дүгнэлтийг өгч байна.

1. Бооцоот морин уралдаан зохион байгуулахад зориулсан зам талбай, барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бүхий морин тойруулгын цогцолбор байгуулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох;
2. Тусгай зөвшөөрлийн тоог хязгаартай олгохоос гадна сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг тусгах;
3. Бооцоот морин уралдааныг зохион байгуулалтын асуудлыг тусгах;
4. Бооцоот морин уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлогоос татвар тогтоох, татварын зарцуулалтыг тодорхойлох;
5. Хурдан морь унахад тохиромжтой бие бялдар, нас, оюун ухааны хувьд өөрийн болоод бусдын үйлдлийг ойлгох, өөрт үүсч болох эрсдэлийг бүрэн ойлгож, ухаарах насанд хүрсэн хүнийг бооцоот хурдан морины уралдаанд оролцуулах, өөрөөр хэлбэл 18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдааны морь унуулахыг хориглох.
6. Олон нийтийг бооцоот тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

## ЭХ СУРВАЛЖ

### Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
3. Үндэсний их баяр наадмын тухай хууль (2003)
4. Биеийн тамир спортын тухай (2003)
5. “Хурдан морины уралдааны дүрэм” Засгийн газрын 2005 оны 119-р тогтоол
6. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоол – “Үндэсний морин уралдааны морины уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2011”
7. “Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 34 дүгээр тогтоол Хурдан моринд тавих ерөнхий шаардлага буюу MNS6464:2014”
8. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/49 дүгээр тушаалаар Монгол үүлдэр, омгийн адуу стандарт/MNS4099:2010

### Ном, судалгаа шинжилгээний бүтээл

1. “Хаврын хурдан морины уралдаан дахь хүүхдийн эрх” судалгаа Хүний эрхийн үндэсний комисс, 2015 он
2. “Хурдан мориноос унаж амь насаа алдсан 25 хүүхдийн гэгээн дурсгалд зориулав” Хууль зүйн профессор О.Мөнхсайхан, 2017 он
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
4. Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны удирдамж тайлан” (ХЭҮК, 2006),

### Цахим эх сурвалж

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. Э.Номин-Эрдэнэ, “Жилд 300 гаруй хүүхэд мориноос унаж эмнэлэгт ханддаг,” Өдрийн Сонин, 2015.10.21,<https://dnn.mn/>
3. Б.Од “Зөвшөөрөлгүй хурдан морины уралдааны үеэр 12 настай хүүхэд унаж бэртжээ”, Зууны мэдээ сонин,2022.02.09,<https://www.zms.mn/a/88379>
4. <https://www.ird.gov.hk/eng/tax/bdu.htm>
5. <https://www.kra.co.kr/globalEn/koreaRacingAuthority.do>
6. <https://www.gov.uk/guidance/general-betting-duty-pool-betting-duty-and-remote-gaming-duty>
7. <https://turbotax.intuit.com/tax-tips/jobs-and-career/how-to-pay-taxes-on-gambling-winnings-and-losses/L7JNH7mjn>



**БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДЛААЧ: М.ЗОЛЗАЯА

## **АГУУЛГА**

### **Ерөнхий зүйл**

**Нэг.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох:**

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Практикт хэрэгжих боломж
- 3.Ойлгомжтой байдал
- 4.Харилцан уялдаа.

**Хоёр. Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох:**

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Практикт хэрэгжих боломж
- 3.Ойлгомжтой байдал
- 4.Харилцан уялдаа.

**Гурав.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх.**

**Дөрөв. Хуулийн төслийн үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх:**

- 4.1.Үр дүнг баримтжуулах;
- 4.2.Үнэлэлт, дүгнэлт;
- 4.3.Зөвлөмж өгөх.

**Тав.Ашигласан материалын жагсаалт.**

# БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль<sup>1</sup>, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”<sup>2</sup> /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан эхний хувилбар буюу ХЗДХС-ын холбогдох байгууллагуудаас санал авахаар 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/4295 тоот албан бичгээр хүргүүлсэн хувилбарт хийсэн болно.

## НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа.

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/-ийг тодорхойлох зорилгоор сонгов.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ, тэдгээрт тухайн зохицуулалтыг

<sup>1</sup> УИХ-аас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

<sup>2</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц/ байгаа эсэхийг шалгаж тогтоох үүднээс сонгон авлаа.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор сонголоо.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн дотооддоо болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах үүднээс хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцсэн эсэх, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох зорилгоор аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтээс “хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ыг сонгоогүй бөгөөд Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.8-д “Тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол “Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд дараах байдлаар судалгаа хийнэ” гэж, 4.8.1-д “хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн бус байгууллагаас санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдийн хүрээнд ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судална” гэж заасан боловч хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд нь уг хуулиар байгуулагдах нийтийн эрх зүйн этгээд байх тул асуулга явуулах боломжгүй байна.

Иймд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийж, бодит үр дүн гарахгүй тул тус шалгуурыг сонгоогүй болно.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**“Зорилгод хүрэх байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан үнэлэх хэсгээ тогтооно.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон тандан судалгаагаар тус хуулийн төслийн үндсэн зорилго нь бооцоот морин уралдааны эрх зүйн орчныг бий болгох зорилгоор анхдагч хуулийн төсөл боловсруулна. Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоож, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.<sup>3</sup> гэжээ.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн

<sup>3</sup> Бооцоот морин уралдааны тухай хуулийн үзэл баримтлал, 2022 он, 4 дүгээр тал

дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоох.</p>	<p><u>Хуулийн төслийн 12 дугаар зүйл. Морин уралдааны холбоо, түүний гишүүнчлэл</u></p> <p>12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.</p> <p><u>Хуулийн төслийн 13 дугаар зүйл. Морин уралдааны холбооны чиг үүрэг</u></p> <p>13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:</p> <p>13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;</p> <p>13.1.2.морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;</p> <p>13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;</p> <p>13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.</p> <p>13.2.Холбоо дараах үүрэгтэй:</p> <p>13.2.1.хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;</p> <p>13.2.2.зохих татварыг хуульд заасан журам, хэмжээгээр төлөх;</p> <p>13.2.3.зориулалтын техник хэрэгсэл, сүлжээ, программ хангамж, хяналтын дууны, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон байх;</p> <p>13.2.4.хууран мэхлэх, залилах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;</p> <p>13.2.5.мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдөх, мөнгө угаах, терроризмтай тэмцэх үндэсний болон олон</p>

	<p>улсын байгууллагаас тавьж байгаа шаардлагыг биелүүлэх;</p> <p>13.2.6.бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалыг оролцогчид болон олон нийт танилцах боломжтой байдлаар нээлттэй байлгах, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, бүртгүүлэх;</p> <p>13.2.7.хуульд заасан бусад.</p> <p>13.3.Холбоо бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох үүрэгтэй.</p> <p><u>Хүүлийн төслийн 8 дугаар зүйл. Бооцоот уралдаанд хориглох үйл ажиллагаа</u></p> <p>8.1.Холбоонд бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотой дараах зүйлийг хориглоно:</p> <p>8.1.1.оролцогч, уяач, унаачийг хууран мэхлэх зорилгоор уралдааны үр дүнг өөрчлөх, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хохироох;</p> <p>8.1.2.хожсон оролцогч, уяач, унаачид хонжворыг төлөхөөс зайлсхийх, татгалзах;</p> <p>8.1.3.морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог хуваарилах дүрэм, бооцоот уралдааны мөнгөн кассын дүрмийг зөрчих;</p> <p>8.1.4.оролцогчоор дамжуулан бооцоо тавих, оролцогчийн бооцоо тавих шийдвэр гаргахад дотоод мэдээллийг ашиглуулах, давуу тал үүсгэх боломж олгох;</p> <p>8.1.5.санаатайгаар, эсхүл зохион байгуулалттайгаар шударга бусаар бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх, уралдаанд оролцож байгаа унаач, морийг түрүүлүүлэх, хожигдуулахаар урьдаас үгсэн хуйвалдах;</p> <p>8.1.6.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан агуулгатай, эсхүл мөрийтэй тоглоомын донтолт үүсгэхүйц хэлбэрээр зар сурталчилгаа явуулах;</p>
--	--

		<p>8.1.7.Зөвлөлийн хориглосон бусад үйл ажиллагаа.</p> <p>8.2.Оролцогч, уяач, унаач, Холбоо болон бусад этгээд бооцоот уралдааны үр дүнд нөлөөлөх зорилгоор хуйвалдах, шударга бус үйлдлээр бооцоот уралдааны бусад оролцогчдын эрхийг зөрчих, хохирол учруулахыг хориглоно.</p>
2.	<p>Бооцоот морин уралдааны харилцаанд оролцох бусад этгээдүүд буюу бооцоо тавьж оролцогч, морин уралдааны унаач, уяачдын эрх зүйн байдлыг тодорхойлох.</p>	<p><u>Хүүлийн төслийн 9 дүгээр зүйл. Оролцогч</u></p> <p>9.1.Бооцоот уралдаанд оролцогч нь 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.</p> <p>9.2.Холбоо нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу оролцогчийг таньж мэдэх үүрэгтэй байна.</p> <p><u>Хүүлийн төслийн 10 дугаар зүйл. Уяач</u></p> <p>10.1.Бооцоот уралдаанд морио уралдуулах уяач Холбооны гишүүн байна. Бооцоот уралдаанд Холбооны гишүүнчлэлтэй уяач морио уралдуулах эрхтэй байна.</p> <p>10.2.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа морин тойруулгын дүрмийн дагуу Холбоонд бүртгүүлэх бөгөөд нэг морины бүртгэлд хоёроос дээш уяач бүртгэхгүй.</p> <p>10.3.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахдаа сайн дураар даатгуулж болно.</p> <p>10.4.Уяач өөрийн өмчлөлийн морийг бооцоот уралдаанд уралдуулахад морин тойруулгын дүрмийг мөрдөх бөгөөд дүрмээр зохицуулаагүй харилцааг гэрээгээр тохиролцож болно.</p> <p><u>Хүүлийн төслийн 11 дүгээр зүйл. Унаач</u></p> <p>11.1.Бооцоот уралдааны унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 18 насанд хүрсэн хүн байна.</p> <p>11.2.18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдаанд морь унуулахыг хориглоно.</p>

		<p>11.3.Холбоо унаачийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэлээр хангана.</p> <p>11.4.Унаач ослын даатгалд даатгуулсан байна.</p> <p>11.5.Унаачийг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бэлтгэх бөгөөд холбогдох харилцааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.</p> <p>11.6.Бооцоот уралдааны аюулгүй байдлын дүрмийг Зөвлөл батална.</p> <p>11.7.Уралдуулсан морь нь бооцоот уралдаанд түрүүлсэн болон бооцоот уралдаанд шагналт байранд орсон тохиолдолд морин уралдааны бооцооноос олсон орлогоос уяач болон унаач нарын хүртэх хувь хэмжээг бооцоог хуваарилах дүрэм, аргачлалын дагуу олгоно.</p>
3.	<p>Бооцоот морин уралдаан зохион байгуулагчийн төлөх татварын төрөл, хувь хэмжээг тогтоож, төвлөрүүлсэн татварын орлогын зохих хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаа, болон соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад тус тус зарцуулах.</p>	<p><u>Хуулийн төслийн 21 дүгээр зүйл. Холбооны төлөх татварын орлого, зарцуулалт</u></p> <p>21.1.Уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлогод Онцгой албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна.</p> <p>21.2.Уралдааны хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна. Холбоо татвар суутгагчийн үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>21.3.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу төвлөрүүлсэн татварын орлогын 15 хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаанд, мөн 15 хувийг соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулан зарцуулна.</p> <p><u>Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл</u></p> <p>1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд дараах агуулгатай 21.1.15 дахь заалт нэмсүгэй:</p> <p>“21.1.15.онцгой албан татвар ногдуулсны дараах казино, бооцоот морин уралдааны үйл ажиллагаанаас олсон орлого.”</p>



4.	<p>Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгах.</p>	<p><u>Хуулийн төслийн 23 дугаар зүйл. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт</u></p> <p>23.1.Зөвлөлийн ажлын алба бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, эсхүл гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.</p> <p>23.2.Уралдаан зохион байгуулах үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирсэн тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд Холбоонд хүргүүлсэн хугацаатай албан шаардлагын биелэлтийг шалгах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.</p> <p>23.3.Улсын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.3.1.бооцоот морин уралдааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>23.3.2.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанаас үнэ төлбөргүй гаргуулан авах;</p> <p>23.3.3.хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох, хяналт шалгалтын явцад зөрчлийн ул мөр, нотлох баримт цуглуулах, зөрчлийн талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор шалгагдаж байгаа этгээдийн бие, албан тасалгаа, бичиг баримт, компьютер, эд зүйлд үзлэг хийх, шаардлагатай баримт материал, эд зүйлийг түр хураан авах;</p> <p>23.3.4.бооцоот уралдааны үйл ажиллагааны явцын хяналтын дуу, дүрс, бичлэгийг шалгах;</p> <p>23.3.5.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.</p>
----	--	--

**“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Хуулийн төсөлд шинээр бий болгож байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах 3 зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект хэн байх вэ, тэдгээр нь уг зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалган тогтоох үүднээс сонгон авлаа.

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.

2.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

3.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:

13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;

13.1.2.морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;

13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;

13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;

13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар сонгов.

“**Харилцан уялдаа**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хуулийн төслийг бусад хуультай нийцсэн, уялдсан эсэхийг шалгах тул бүхэлд нь шалгахаар сонголоо.

### **ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг дээрх 2 үе шатанд тус тус тогтоосны дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1.	Зорилгод хүрэх байдал	Энэхүү үнэлгээний тайлангийн Хоёр дахь хэсэг буюу Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхээр сонгосон зохицуулалтууд. /Үнэлгээний тайлангийн 5-9 дүгээр хуудас/	<b>Зорилгод дүн шинжилгээ хийх:</b> Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 12.1, 13.1 дэх хэсэг	<b>Санал авч, дүн шинжилгээ хийх:</b> Уг зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллага дээр туршилт хийх боломжгүй тул адил төстэй үйл ажиллагаа явуудаг хуулийн этгээдийн мэдээлэл болон олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлэх замаар шалгана.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл 7 бүлэг, 25 зүйлтэй/	<b>Ойлгомжтой байдлыг шалгах:</b> Хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс уг төсөл нь ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгана.
4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл 7 бүлэг, 25 зүйлтэй/	<b>Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:</b> Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

### 3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд<sup>3</sup> тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” гэж, 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Тус хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байх” зорилтыг дэвшүүлж, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.47-д “...аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4-т Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх

бодлогын хүрээнд “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ” гэж, мөн 2.6-д заасан Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох зорилтын хүрээнд “... соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна” гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслийг боловсруулан, батлуулахаар тусгажээ.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага гарсан байх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан, түүнчлэн хуулийн төсөлд бүрэн дүүрэн, хангалттай тусгаж чадсан эсэхэд дараах байдлаар үнэлэлт, дүгнэлт хийлээ. Үүнд:

***1.Монгол Улсын нутаг дэвсгэрт бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг байгуулах, түүний чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагааг тогтоох.***

Энэ хэрэгцээ шаардлагын хүрээнд хуулиар бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх нийтийн эрх зүйн этгээдийг байгуулж, зохион байгуулалтын бүтцийг нарийвчлан тусгаснаас гадна хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой зааснаас гадна бооцоот морин уралдаанд хориглох үйл ажиллагааг тогтоосон нь үзэл баримтлалын дээрх хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Тухайлбал нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан агуулгатай, эсхүл мөрийтэй тоглоомын донтолт үүсгэхүйц хэлбэрээр зар сурталчилгаа явуулахыг хориглосноос ганда оролцогчийг бооцоот уралдаанд зээлээр оролцуулах, морин тойруулгын цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглосон зохицуулалтыг тусгасан нь олон нийтийг бооцоот тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх зорилгод нийцэж байна.

Харин үзэл баримтлалд бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг тогтоохоор заасан боловч хуулийн төсөлд зөвхөн морин тойруулгад тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг тусгаагүй болохыг анхаарах нь зүйтэй байна.

Хуулийн төсөлд тусгаснаар бооцоот морин уралдаан зохион байгуулах цорын ганц этгээд нь энэ хуулиар байгуулагдах Холбоо байх бөгөөд тухайн этгээдэд хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээлгэсэн зохицуулалтын хүрээнд тухайн этгээдэд тавигдах шаардлагыг хуулиар тогтоох хэрэгцээ хангагдах эсэхийг дахин нягтлах шаардлагатай байна.

***2.Бооцоот морин уралдааны харилцаанд оролцох бусад этгээдүүд буюу бооцоо тавьж оролцогч, морин уралдааны унаач, уяачдын эрх зүйн байдлыг тодорхойлох.***

Энэ хэрэгцээ шаардлагын хүрээнд хуулийн төслийн гуравдугаар бүлэгт бооцоот морин уралдаанд 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн бооцоо тавьж оролцож болохоор, мөн уяач нь Холбооны гишүүнчлэлтэй тохиолдолд морио уралдуулах боломжтой болохыг тодорхой заасан нь тухайн харилцаанд оролцогчдод тодорхой, ойлгомжтой болсон байна.

Мөн бооцоот морин уралдааны зохион байгуулагч нь “бооцоот уралдаанд цугларсан нийт орлогын 60-аас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгох” үүргийг тусгасан нь оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах агуулгыг тусгасан нь үзэл баримтлалын дээрх хэрэгцээ шаардлагад нийцсэн байна. Түүнчлэн 18 насанд хүрээгүй хүнээр бооцоот уралдаанд морь унуулахыг хориглосон нь унаач хүүхдийн эрхийн асуудал хөндөгдөхөөргүй байна.

Харин унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд байх шаардлагыг тусгасан нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч хэрэгжүүлэх этгээдийн тухайд тодорхойгүй нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

Тодруулбал Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах” асуудал нь Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэн эрх хамаарна.

9 дүгээр зүйлийн 9.1-д “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид ажил, мэргэжлийн үндэсний ангиллаар тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ” гэж заасан бөгөөд ажил, мэргэжлийн үндэсний ангилал болох “YAMAT-08”-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалаар баталсан байна.

Дээрх “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал”-д унаачын ажил, мэргэжил хамаарахгүй байх тул унаачын мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулгыг тодорхойлох эрх зүйн үндэслэлгүй болохыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

***3.Бооцоот морин уралдаан зохион байгуулагчийн төлөх татварын төрөл, хувь хэмжээг тогтоож, төвлөрүүлсэн татварын орлогын зохих хувийг бэлчээрийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх ажиллагаа, болон соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад ажиллагаанд тус тус зарцуулах.***

Татвартай холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгаж, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан нь үзэл баримтлалд заасан уг хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Харин татварын хувь хэмжээ тогтоосон нэмэлт, өөрчлөлтүүдийн зарим зохицуулалтыг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг дагалдуулж боловсруулсан байна.

Тодруулбал Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг болно. Хэдийгээр Казиногийн тухай, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүд нь хамтаар боловсруулагдаж байгаа боловч тус тусын үзэл баримтлалын хүрээнд

боловсруулагдаж байгаа тул дагалдаж боловсруулах хуулийн төслүүдийг нэгтгэх боломжгүйг анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа татвар төлөгчийн үйл ажиллагааны нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 60 хувиар” татвар ногдуулахаар заасан байна. Хуулийн төсөлд “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа” гэдгийг хэрхэн ойлгох талаар нэр томъёоны тайлбар байхгүй бөгөөд хуулийн төслийг бүхэлд нь авч үзвэл Холбооны гүйцэтгэх чиг үүрэг /бооцоот уралдаан зохион байгуулах;, морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;, бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;, мэргэжлийн унаачын эрх олгох/-ийг нийтэд нь “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа” гэж ойлгохоор байна. Энэ нь эргээд татвар ногдуулах орлогыг тооцоход төөрөгдөл үүсгэж болзошгүй байна.

Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч татвар ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байх тул нарийвчилсан зохицуулалтыг татварын тухай хуулиар тусгах нь зүйтэй гэж үзлээ.

***4.Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тусгах.***

Хуулийн төсөлд мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах үүрэг бүхий Зөвлөлийн чиг үүргийг тодорхойлж, өөрийн ажлын албаар дамжуулан бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт тавихаар тусгасан нь үзэл баримтлалд заасан уг хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үзэж болохоор байна.

Зөвлөлийн ажлын алба нь төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн гэсэн 2 хэлбэрээр хяналт тавихаар тодорхой заасан боловч хяналтыг хэрхэн, ямар хугацаанд, ямар байдлаар тавих нь тодорхойгүй байх тул уг асуудлыг нягталж, журамлах шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй байна.

**3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс сонгож авсан дээрх зохицуулалтыг дагаж мөрдөх болон хэрэгжих боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийн эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект нь хэн байх, тэдгээрт энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэхийг шалгахыг зорилоо.

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан эрх зүйн зохицуулалтууд нь бодитой хэрэгжих боломжтой эсэхийг судлах замаар үр нөлөөг үнэлэх бөгөөд хуулийн төсөлд тусгаснаар бооцоот морин уралдааны үйл ажиллагааг “Монголын морин уралдааны холбоо” /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулахаар заасан бөгөөд тухайн Холбоог энэ хуулиар үүсгэн байгуулж байна.

Иймд туршилт явуулахад хамрагдах холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломжгүй гэж үзээд, адил төстэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн мэдээлэлд үнэлгээ хийхээс гадна, олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлнэ.

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.

2.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

12.1.Монголын морин уралдааны холбоо нь үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

3.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

13.1.Холбоо дараах чиг үүрэгтэй байна:

- 13.1.1.бооцоот уралдаан зохион байгуулах;
- 13.1.2.морь амраах/сэрүүцүүлэх үйлчилгээ эрхлэх;
- 13.1.3.бооцоот морин уралдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх;
- 13.1.4.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;
- 13.1.5.мэргэжлийн унаачийн эрх олгох.

➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн сан<sup>4</sup>-гаас үзэхэд хурдан морины уралдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийт 96 төрийн бус байгууллага бүртгэгдснээс нийтэд үйчилдэг төрийн бус байгууллага 87, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага 19 байна. Эдгээр төрийн бус байгууллагаас нэг хуулийн этгээд ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг бол нийт 95 төрийн бус байгууллага морин уралдааны чиглэлээр ашгийн бус үйл ажиллагаа эрхэлж байна.

Дээрх төрийн бус байгууллагууд үйл ажиллагааны чиглэлийг үзвэл морин спортын уралдааны төрлийг хөгжүүлэх, зохион байгуулах, сурталчлах зэрэг үйл ажиллагаа нийтлэг байдлаар эрхлэхээс гадна, хурдан морины үүлдэр угсаа, угшлыг тодорхойлох, сайжруулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг байна. Хэдийгээр эрх зүйн орчин байхгүй боловч мэргэжлийн унаач буюу жокей бэлтгэдэг<sup>5</sup> байна.

➤ Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудад практикт туршигдсан, хэрэгжих боломжтой болох нь дараах судалгаануудаас харагдаж байна. Үүнд:

### **Хонг Конг**

Хонг Конгийн Жокэй Клуб нь ойролцоогоор 135 жилийн түүхтэй ашгийн төлөө бус байгууллага бөгөөд Хонг Конгод монополь эрхтэйгээр бооцоот морин уралдаан зохион байгуулдаг. 7 хоногийн 2 өдөр морин уралдаан зохион байгуулах бөгөөд бооцооноос цугласан орлогоос бооцоо тавигчдад буцаан өгсөн дүнг хассаны дараах дүнгийн 72,5 хувийг татварт төлдөг байна.<sup>6</sup> (Харин бооцооны хожлоос ХХОАТ авдаггүй) Тус

<sup>4</sup> <http://opendata.burtgel.gov.mn/>

<sup>5</sup> <https://gogo.mn/r/e7v38>

<sup>6</sup> <https://www.ird.gov.hk/eng/tax/bdu.htm>

байгууллага нь Хонконгийн хамгийн том татвар төлөгч төдийгүй олон нийтийн хамгийн том буяны байгууллага юм.

Хүн амын тоо олон, нэг л байгууллага монополь эрхтэйгээр үйл ажиллагаа явуулдаг, бусад төрлийн бооцоотой, мөрийтэй тоглоом хууль бус байдаг зэргээс шалтгаалан морин уралдаан үзэгч, бооцоот уралдаанаас олох орлого нь жилээс жилд буурахгүй, харин өсөх хандлагатай байдгаараа онцлог байна. Түүнчлэн клуб нь 4 төрлийн гишүүнчлэлтэй бөгөөд гишүүнчлэлийг олгох шалгуур нь өндөр тул энэ нь тухайн хүний нийгэм дэх байр суурь, нэр хүндийн илэрхийлэл болдог нь мөн нөлөөлдөг байна. 2013 оны байдлаар гишүүнчлэлийн хураамж 400,000 хонконг доллар, сар бүр 1,800 хонконг долларын хураамжтай бөгөөд гишүүнчлэлийг дамжуулан худалдаж авахыг зөвшөөрдөггүй байна.

## **Эстони**

Эстони Улсын Мөрийтэй тоглоомын тухай хууль нь бүх төрлийн мөрийтэй, бооцоот тоглоомын харилцаанд үйлчлэхээр зохицуулсан бөгөөд үүнд бооцоот морин уралдаанд мөрий тавих харилцаа хамаарч байна. Уг харилцаатай холбоотой татварын маргаан шийдвэрлэлт, татварын байгууллагын эрх, үүргийн талаар Татварын тухай хуульд, мөрийтэй тоглоомтой холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх санхүүгийн тогтолцоо, эдийн засгийн орон зайн талаар Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуульд, Зар сурталчилгааны тухай хуулиар мөрийтэй тоглоомыг сурталчлахтай холбоотой хориглох талаар зохицуулсан байдаг. Хамгийн сүүлийн мөрийтэй тоглоомын тухай хуулийг 2008 онд баталж, 2009 оны эхээр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү хууль тогтоомжийн гол давуу тал нь хурдацтай хөгжиж буй онлайн мөрийтэй тоглоомын салбарыг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн явдал юм. Энэхүү хууль нь өнөөгийн Эстони улсад мөрийтэй тоглоомын салбарыг зохицуулдаг. Энэхүү акт хүчин төгөлдөр болохоос өмнө хоёр үндсэн хууль тогтоомжийг ашиглаж байсан - 1995 оны мөрийтэй тоглоомын тухай хууль, 1994 оны сугалааны тухай хууль. Мөрийтэй тоглоомын салбар дахь технологийн хурдацтай хөгжлийн улмаас эдгээр хоёр акт тун удалгүй хангалтгүй болсон. Ялангуяа онлайн мөрийтэй тоглоомын үйлчилгээ зохицуулалтгүй хэвээр үлдсэн байна.

1995 онд батлагдсан Мөрийтэй тоглоомын тухай хууль нь мөрийтэй тоглоомын 4 төрлийг, тухайлбал, азын тоглоом, ур чадварын тоглоом, тотализатор, бооцоо зэргийг нэвтрүүлсэн. Энэхүү хуулийн дагуу мөрийтэй тоглоомын үйлчилгээ эрхлэх боломжтой байхын тулд бүх операторууд үйл ажиллагааны лиценз, үйл ажиллагааны зөвшөөрөл авсан байх ёстой. Бүх төрлийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатайгаар олгохоор тусгасан. Ашиглалтын зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай бөгөөд мөрийтэй тоглоомын газар хаана ажилууллахыг зааж өгсөн байна. Тусгай зөвшөөрлийн өргөдөл нь татгалзсан өргөдөл гаргагчид асуудлыг шийдвэрлэхийн тулд захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой байна.

Мөрийтэй тоглоомын тухай шинэ хууль нь өмнөх 2 үйлдлийг хүчингүй болгосон боловч ихэнх гол зохицуулалтууд өөрчлөгдөөгүй хэвээр үлджээ. Ялангуяа 1995 онд Мөрийтэй тоглоомын тухай хуульд заасан 4 төрлийн мөрийтэй тоглоомыг шинэ хуульд мөрийтэй тоглоомын үндсэн ангилал гэж тодорхойлсон болно. Мөрийтэй тоглоомын үйлчилгээг хууль ёсны дагуу санал болгох үйл ажиллагааны зөвшөөрөл авах шаардлага мөн өөрчлөгдөөгүй хэвээр байна. Эстони нь Европын холбооны гишүүн улс тул мөрийтэй тоглоомын тухай хууль нь Олон нийтийн хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Гэсэн хэдий ч ЕХ-ны бусад орнуудад тусгай зөвшөөрөл авсан операторууд ч зөвшөөрөлгүй хүмүүсийн адил шаардлагыг хангаж, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа,



ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргаж, Эстонийн татвар, гаалийн зөвлөлд хууль эрх зүйн болон тогтвортой байдлыг хангах чадвартай гэдгээ нотолж өгөх ёстой. Эдгээр хатуу дүрмүүд нь Европын Комиссоос сурталчилж буй чөлөөт өрсөлдөөний зарчмуудтай зөрчилдөж байгаа боловч Эстонийн эрх баригчид мөрийтэй тоглоомын салбарыг зохих журмын дагуу зохицуулж байна.

## **Кени Улс**

Кенийн Үндэсний Ассемблей нь бооцоот тоглоомын зохицуулалтын хүрээг шинэчлэн боловсруулж, тусгай зөвшөөрөлтэй оператор компаниудад илүү өндөр зардал ногдуулж, тус улсын анхны үндэсний сугалааг байгуулах хуулийн төслийг хэлэлцэж 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 1966 оны бооцоо, хонжворт сугалаа, бооцоот тоглоомын тухай хуулийг орлох зорилгоор боловсруулсан Тоглоомын тухай хуулийг 2019 онд онлайн операторуудын зах зээл дээрх тэргүүлэх байр суурийг тусгах зорилгоор тус улсын журмыг шинэчлэх зорилготойгоор хуулийн төслийг шинэчилж байгаа бөгөөд энэ нь тус улсын одоо байгаа зохицуулах эрх бүхий байгууллага болох Бооцоо тоглоомын тусгай зөвшөөрлийн хяналтын зөвлөлийг шинэ тоглоомын газар болох Үндэсний тоглоомын газартай хамт солихыг санал болгож байна. Хуулийн төсөлд шинэ зохицуулах байгууллага байгуулахын зэрэгцээ бооцоот тоглоомтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэх байгууллага болох Тоглоомын хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулахаар тусгажээ.

Морин уралдаанд бооцоо тавих харилцааг хуулиар зөвшөөрч, олон жил практикт хэрэгжүүлсэн дээрх улс орнуудын хууль тогтоомж, практикт тулгуурлан олон улсын жишигт нийцүүлэн Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.

Мөн Монгол үндэстний дэлхийд бахархах өв соёл болох Монгол наадмын морин уралдааны харилцааг хөндөхгүйгээр 18 наснаас дээш насныхан уралддаг бүх улирлын морины уралдааны шинэ төрлийн спорт, түүний эрх зүйн зохицуулалтыг бий болгож, олон улсад хэрэгжүүлж буй эрх зүйн зохицуулалтын сайн туршлагаас Монгол Улсад нутагшуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь унаач хүүхдийн эрхийг хамгаалах, соёлын өв болох хурдан морийг дэлхийд сурталчлах, түүгээрээ дамжуулан жуулчид татах, түүнчлэн бооцоот морин уралдаан зохион байгуулах бизнесийг дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой гэж хуулийн төслийн тандан судалгаагаар тогтоосон байна.

### **3.4. “Ойлгомжтой байдлыг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг дараах байдлаар шалгаж тогтоохыг зорьлоо. Үүнд:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1/4295 тоот албан бичгээр хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авсан байх бөгөөд эдгээр байгууллагуудын саналд “Ойлгомжтой байдал” гэсэн шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;

2.Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэхийг шалгах.

*1.Байгууллагуудаас ирүүлсэн саналд “Ойлгомжтой байдал” гэсэн шалгах хэрэгслийг ашиглан үнэлгээ хийсэн байдал:*

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс судлаачийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Д/д	Хуулийн төслөөс ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар	Санал
1.	3.1.1.“бооцоо” гэж морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааны үр дүнгийн талаар аз туршсан таамаг дэвшүүлж, таамаг нь таарсан тохиолдолд дүрмийн дагуу өсгөж авах, таамаг таараагүй тохиолдолд алдагдал хүлээх эрсдэлийг хүлээж тоглоом зохион байгуулагчид оролцогчоос сайн дураараа шилжүүлж өгсөн мөнгөн хөрөнгийг;	Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.2-д “бооцоо гэж бооцоот үйл явдлын үр дүнгээс шалтгаалж дэвшүүлсэн таавар нь таарсан тохиолдолд дүрэмд зааснаар өсгөж авах нөхцөлтэйгээр эрсдэлээ өөрөө хариуцаж, зохион байгуулагчид сайн дураараа шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг” гэж нэг нэр томьёог өөр өөрөөр ойлгохоор тусгасан нь зөрчил, ойлголтын зөрүү үүсгэж болзошгүй байна.	Томьёоллын агуулга ижил төстэй байх тул агуулгыг найруулж, нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар томьёолох.
2.	3.1.4.“оролцогч” гэж бооцоот уралдааны үр дүнгийн талаар аз туршсан таамаг дэвшүүлж, учирч болох эрсдэлээ хүлээн зөвшөөрч, морин уралдаанд бооцоо тавьж оролцож байгаа хувь хүнийг;	Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.8-д “оролцогч гэж өөрийн азыг туршиж сугалааны тасалбар худалдан авч байгаа, эсхүл бооцоот үйл явдлын үр дүнгийн талаар таавар дэвшүүлэн бооцоо тавьж байгаа хүнийг” гэж нэг нэр томьёог өөр өөрөөр ойлгохоор тусгасан байна.	Томьёоллын агуулга ижил төстэй байх тул агуулгыг найруулж, нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар томьёолох.
3.	4 дүгээр зүйл. Бооцоот уралдааны үйл ажиллагаанд баримтлах зарчим  7 дугаар зүйл. Бооцоот морин уралдааны журам  8 дугаар зүйл. Бооцоот уралдаанд хориглох үйл ажиллагаа	Зүйлийн доторх агуулга нь бооцоот уралдаан зохион байгуулах харилцаанд хамаарч байна.	Зүйлийн доторх агуулгад нийцүүлэн зүйлийн нэрийг “үйл ажиллагаа” гэснийг “зохион байгуулахад” гэж өөрчлөх.
4.	12.1.Монголын морин уралдааны холбоо нь	Төслөөс үзэхэд бооцоот уралдаан зохион	Энэ тохиолдолд өмчийн хэлбэрийг тодорхой

	үндэсний өв соёл, уламжлал, морин уралдааныг олон нийтэд сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан, сайн дурын гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.	байгуулах Холбоо нь нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын шинжтэй байх бөгөөд өмчийн хэлбэр нь төрийн оролцоогүй байна.	болгох, төрийн оролцоог тодорхойлох
5.	3.1.2.“бооцоот морин уралдаан” /цаашид “бооцоот уралдаан” гэж/ гэж эрх бүхий этгээд тогтоосон дүрмийн дагуу морин тойруулгад зохион байгуулж байгаа морин уралдааныг;	цаашид “бооцоот уралдаан” гэхээр заасан боловч төслийн 3.1.3, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 13.1.3-т тус тус “бооцоот морин уралдаан” гэж тусгасан байна.	Холбогдох заалтуудын нэр томъёог жигдлэх.

*2.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгасан байдал:*

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.

29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Эшлэлийг хийсэн боловч Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг эш татахдаа хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заагаагүй байх тул энэ шаардлагыг хангах нь зүйтэй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Шаардлага хангасан.

### 3.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр

хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцсэн.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.

Хуулийн төслөөр “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарч байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байна.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх.

Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй байна.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх.

/Энэ талаар үнэлгээний тайлангийн практикт хэрэгжих боломж шалгуураар үнэлсэн хэсэгт тодорхой тусгасан болно./

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх -

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх -

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх

Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт тавих асуудал нь төрийн зүгээс хяналт, хариуцлага оногдуулах шинжтэй харилцаа тул төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй юм.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх. (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулна.)

*11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх.*

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

*12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;*

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

*13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх.*

Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.

*14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.*

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

*15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.*

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

*16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.*

Хуулийн төслийг дагалдах хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдсан.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5 дахь хэсэгт заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

- 4.1.үр дүнг баримтжуулах;
- 4.2.үнэлэх;
- 4.3.зөвлөмж өгөх.

**4.1.Үр дүнг баримтжуулах:** Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “зорилгод хүрэх байдал”, “практикт хэрэгжих боломж”, “ойлгомжтой байдал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох шалгах хэрэгслийг ашиглан хийсэн бөгөөд ийнхүү үр нөлөөний үнэлгээг хийхдээ шаардлагатай хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг материалыг цуглуулж ашиглан, эдгээр материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргав.

**4.2.Дүгнэлт:** Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасан 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

**“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг бүрэн тусгасан боловч зарим зохицуулалт хангалтгүй буюу нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзлээ. Бооцоот морин уралдаан зохион байгуулах цорын ганц этгээд нь энэ хуулиар байгуулагдах Холбоо байх бөгөөд тухайн этгээдэд хууль тогтоомж болон Зөвлөлөөс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээлгэсэн зохицуулалтын хүрээнд тухайн этгээдэд тавигдах шаардлагыг хуулиар тогтоох хэрэгцээ хангагдах эсэхийг дахин нягтлах шаардлагатай мөн унаач нь морь уралдуулах чадвар, дадлыг эзэмшүүлэх морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд байх шаардлагыг тусгасан нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч хэрэгжүүлэх этгээдийн тухайд тодорхойгүй нөхцөл байдал үүсч болзошгүйг дурдсан болно.

**“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 5.1, 12.1, 13.1 дэх хэсгийг үнэлсэн бөгөөд Иймд туршилт явуулахад хамрагдах холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломжгүй гэж үзээд, адил төстэй үйл ажиллагаа явуудаг хуулийн этгээдийн мэдээлэлд үнэлгээ хийхээс гадна, олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг заалтыг хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэв.

**“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох байгууллагуудын ирүүлсэн санал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шалгуурыг хангасан эсэхэд

үнэлгээ хийж холбогдох дүгнэлтийг тайлангийн 3.3. дахь хэсэгт /18-20 дугаар хуудас/ тодорхой тусгасан болно.

### **“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:**

Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт болон шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч татвар ногдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан байх тул татвар ногдуулах, хураахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилсан татварын тухай хуулиар зохицуулах нь зүйтэй.

### **4.3.Зөвлөмж:**

Дээрх дүгнэлтэд үндэслэн хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. **Үүнд:**

#### **Хуулийн төслийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал:**

1. Хуулийн төсөлд Бооцоот морин уралдаан зохион байгуулагчид тавигдах шаардлагыг дахин нягтлах;
2. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 хэсгийг хасах;
3. Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг дагалдуулж боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “бооцоот морин уралдааны үйл ажиллагаа” гэснийг хуулийн төслийн 3.1.3-т заасан нэр томъёонд нийцүүлэн “бооцоот морин уралдаан зохион байгуулах үйл ажиллагаа” гэж өөрчлөх;
4. Хуулийн төслийн 23 дугаар зүйлд “Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмыг Зөвлөл батална.” гэж нэмэх;
5. Төслийн 3.1.1-д “бооцоо” гэх нэр томъёоны тайлбарыг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 4.1.2-т заасан “бооцоо” гэх тодорхойлолттой уялдуулж нэг хуулиас нөгөөд иш татсан байдлаар томъёолох;
6. 4 дүгээр зүйлийн нэрийг агуулгад нийцүүлэн “үйл ажиллагаа” гэснийг “зохион байгуулахад” гэж өөрчлөх;
7. Хуулийн төслийн 3.1.3, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 13.1.3 заалтуудын нэр томъёог жигдлэх.

#### **Бусад санал:**

1. Унаач буюу жокейчины ажлыг албан ёсны ажил мэргэжилд тооцуулах хүрээнд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал”-д нэмэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;
2. Хуулийн төслийн 5.1-д заасан “Монголын морин уралдааны холбоо” гэх оноосон нэрийг давхцалтай эсэх талаар эрх бүхий төрийн байгууллагаас лавлагаа гаргуулах;
3. Бооцоот морин уралдааны үйл ажиллагаанд оролцох хурдан морьдын бүртгэлтийн харилцааг хуулийн төсөлд тусгах.



## ТАВ.АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хууль тогтоомжийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2016 он
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтран баталсан Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
- Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл /2022.09.15-ны өдрийн байдлаарх/
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл /2022.09.15-ны өдрийн байдлаарх/
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн танилцуулга
- Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан.
- 

---ooOoo---

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДЛААЧ:

С.ГАНХУЯГ

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## **АГУУЛГА**

### **Нэг.Ерөнхий мэдээлэл**

**Хоёр.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:**

- 2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.Нэмэлт зардлыг тооцох.

**Гурав.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:**

- 3.1.Төрийн байгууллагын шинээр гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Хүний нөөцийг тогтоох;
- 3.3.Гарах зардлыг тооцох;
- 3.4.Нийт зардлыг нэгтгэн тооцох;

### **Дөрөв.Дүгнэлт**

## **ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **/Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл/**

#### **Нэг.Ерөнхий мэдээлэл**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг дагуу хийлээ.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаарх санал боловсруулах, хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Бооцоот морин уралдаан буюу олон улсын стандартад нийцсэн морин тойруулгад морин уралдаан зохион байгуулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг бий болгосноор эдийн засгийг төрөлжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэгт үр өгөөжтэй гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Энэхүү хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр бичигдсэн бөгөөд тухайн асуудлыг зохицуулж байсан туршлага манай улсад байхгүй тул хуулийн төслийн зардлын тооцоог хийхэд шаардлагатай тоон мэдээллийг баримжаалах замаар тогтоох шаардлагатай болно.

Хуулийн төслийн зохицуулалт нь морин уралдаанд оролцогчийн эрх ашгийг бооцоот морин уралдаан зохион байгуулах этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хамгаалахаар байх бөгөөд ингэснээр иргэнд шууд хүлээлгэсэн үүрэг бүхий зохицуулалт агуулаагүй байна.

Хуулийн төслийн зохицуулалтыг судалж үзсэний үндсэн дээр төсөл нь төр, хуулийн этгээд гэсэн зардал тээгч хоёр субьектэд үүрэг үүсгэсэн зохицуулалт агуулсан буюу тэдгээрт зардал үүсгэхээр байна.

---

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.”, мөн зүйлийн 5.5 дахь хэсэгт “Зөвлөл нь бооцоот уралдааны эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Зөвлөл нь бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан нь **төрд**, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ”, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ” гэж заасан нь **хуулийн этгээдэд** тодорхой зардал үүсгэх зохицуулалт агуулсан байна.


Иймд хуулийн төслийн зардлын тооцоо нь дээрх зохицуулалтын дагуу хуулийн этгээд болон төрд үүсэх захиргааны зардлыг тооцоолон гаргах юм.

## **ХОЁР.БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Энэхүү тооцооны аргачлалаар хуулийн этгээд буюу Бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хуулийн төсөлд тусгагдсан заавал гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээдээс гарах захиргааны зардлыг тооцох юм. Харин бооцоот морин уралдаан зохион байгуулахад шаардлагатай төслийн тооцоолол, хөрөнгө оруулалтын тооцоо хийгдэхгүй болно.

Өөрөөр хэлбэл хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь ямар, ямар үйл ажиллагаа явуулах вэ?, түүнд дунджаар хэдий хэр цаг хугацаа зарцуулах вэ? Үүний цаана ямар хэмжээний мөнгөн зардал гарах вэ? гэдгийг тооцож гаргана.

Дээрх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:



**Хуулийн этгээдийн нийт зардал = Захиргааны зардал + Нэмэлт зардал**

## 2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хамгийн эхний алхам бол хуулийн төслөөс хуулийн этгээдийн гүйцэтгэх зардал бий болгох үүргийг тогтоох үе шат бөгөөд үүнийг дараах дарааллын дагуу гүйцэтгэнэ.



- Хуулийн төслөөс үүрэг болгосон эрх зүйн заалт нэг бүрийг тодорхойлох,
- Үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэх хуулийн этгээд нэг бүрийг тодорхойлж гаргана.

Тухайн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг гэдэгт холбогдох хуулиар тоо баримт, тайлан, бусад мэдээллийг төрийн байгууллага буюу **гуравдагч этгээдэд** бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг **үүрэг** гэдэгт хамааруулан ойлгоно.

Хуулийн төсөлд тусгаснаар бооцоот морин уралдааныг “Монголын морин уралдааны холбоо” буюу нэг этгээд зохион байгуулахаар тусгайлан заасан бөгөөд тухайн этгээдэд дараах үүргийг оногдуулсан байна. Үүнд:

- 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ” гэж;
- 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ” гэж;

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх захиргааны болон бодит зардлыг тооцоолохоос тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг тооцохгүй болно.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг олж тогтоосон тул дараагийн алхам болох **үүргийн агуулга** буюу үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдийн зүгээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тогтоох юм.


Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг тус бүрээр үүргийн агуулгыг жагсаав.

Хүснэгт 1

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Тайлбар
1	5.6.Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ.	Холбооны танилцуулга морин тойруулгын барилга байгууламжийн төсөл болон бооцоот уралдааны үйл ажиллагаа эрхлэх төсөл Холбооны дүрэм харилцагч банкны тодорхойлолт	Хуулийн төслийн 5 дугаар зүйл.
2	7.2.Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.	морин тойруулгын дүрэм бооцоот морин уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлал бооцоот морин уралдааны мөнгөн кассын дүрэм бооцоот морин уралдааны ёс зүйн дүрэм дүрэм, аргачлалыг бүртгүүлэх	Хуулийн төслийн 7 дугаар зүйл.

## 2.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс гарах мөнгөн зардлыг цаг хугацаагаар дамжуулан тооцоолон юм. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг **стандарт үйл ажиллагаа** гэж аргачлалд заасан бөгөөд үүрэг тус бүр өөр өөрийн онцлогтой, тэдгээртэй холбогдуулан хийх үйлдэл ялгаатай байх боловч нийтлэг хийгддэг ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд заасан “Стандарт үйл ажиллагаа”-ны жагсаалтаас ашиглах, мөн энэ нь анхдагч хуулийн төсөл тул бусад ижил төрлийн ажиллагааг харгалзан тогтоох нь зүйтэй байна.

Иймээс стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг



**Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

харгалзан үзэхийн хамт бусад ойролцоо төрлийн үйл ажиллагаа хийгдэх ерөнхий хугацаа зэргийг харгалзан баримжаалсан болно.

Хүснэгт 2

	<b>Хуулиар хүлээсэн үүрэг</b>	<b>Үүргийн агуулга</b>	<b>Стандарт үйл ажиллагаа</b>	<b>Хугацаа</b>
1.	5.6.Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ.	Холбооны танилцуулга	танилцуулга боловсруулах	2 цаг
			танилцуулгын эхийг хянаж, эцэслэх	1 цаг
		морин тойруулгын барилга байгууламжийн төсөл болон бооцоот уралдааны үйл ажиллагаа эрхлэх төсөл	Төслийн судалгаа хийх	60 цаг
			Төслийг боловсруулах	40 цаг
			Төслийг эцэслэх	15 цаг
		Холбооны дүрэм	Дүрмээ тогтоож боловсруулах	40 цаг
		харилцагч банкны тодорхойлолт	Харилцагч банкнаас тодорхойлолт гаргуулах	1 цаг
				<b>219 цаг</b>
2.	7.2.Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.	морин тойруулгын дүрэм	Дүрмээ тогтоож боловсруулах	40 цаг
		бооцоот морин уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм, аргачлал	Дүрмээ тогтоож боловсруулах	40 цаг
		бооцоот морин уралдааны мөнгөн кассын дүрэм	Дүрмээ тогтоож боловсруулах	40 цаг
		бооцоот морин уралдааны ёс зүйн дүрэм	Дүрмээ тогтоож боловсруулах	40 цаг
		дүрэм, аргачлалыг бүртгүүлэх	дүрэм, аргачлалыг бүртгүүлэх	40 цаг
<b>НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА</b>				<b>419 цаг</b>

**Ажлын хөлсийг** тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цагаар гаргана.

Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас болох [www.1212.mn](http://www.1212.mn) байршуулсан судалгааг эх сурвалж болгох юм.

Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар<sup>2</sup> “2022 оны 4 дүгээр сарын байдлаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнесийн байгууллагын оффисын дундаж ажилтан буюу захиргааны ажилтан сард дундажаар 1.574.0 төгрөгийн цалин хөлс авч байгааг судалгаанд дурдсан байна. Иймд хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой ажлын хөлсийг тооцоолохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх судалгааг эх сурвалж болгон ашиглах юм.

Ажиллах хугацааг гаргахдаа Хөдөлмөрийн тухай хуульд<sup>3</sup> заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт 3

<b>Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа</b>	
1.574.000 <sup>4</sup> : 22 <sup>5</sup> өдөр : 8 <sup>6</sup> цаг = 8943 төгрөг /дундажаар ажлын нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлс/	

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа захиргааны зардлыг Танхимд гишүүнээр элсэх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

Хүснэгт 4

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Нэг цагийн ажлын хөлс	Нэг аж ахуйн нэгжийн зардал
1	Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ.	219 цаг	8943 төг	1,958,517
2	Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.	200 цаг	8943 төг	1,788,600
<b>НИЙТ:3,747,117 төгрөг</b>				

<sup>2</sup> [http://1212.mn/BookLibrary/Download.ashx?url=average\\_wage\\_2017.pdf&ln=Mn](http://1212.mn/BookLibrary/Download.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn) /Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

<sup>3</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл.

<sup>4</sup> Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2022 оны 1 дүгээр улиралын байдлаарх сарын дундаж цалин хөлс

<sup>5</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 8 дүгээр зүйлд заасан 7 хоногийн 5 өдөр ажиллах тул сард дундажаар 22 ажлын өдөр байдаг болно.

<sup>6</sup> Хөдөлмөрийн тухай хуульд заасан 1 ажлын өдөрт ажиллах цаг

### 2.3. ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг нэг жилд хэдэн хуулийн этгээд, хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Тоон үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**<sup>7</sup> болон **давтамжийг**<sup>8</sup> холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

<b>ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ</b>
---

Дээрх томъёоны дагуу тоон үзүүлэлтийг тогтоохын тулд тохиолдлын тоо зайлшгүй шаардлагатай байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна” гэж тусгайлан заасан бөгөөд тухайн этгээд дээрх үүргийг хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш нэг удаа гүйцэтгэх юм.

Дээрх томъёог ашиглан хуулийн төслөөр бий болгосон үүрэгт хамаарах тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 5

Д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ.	1	x	1	=	1
2	Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.	1	x	1	=	1

Харин хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2.6-д заасны дагуу Холбоо нь “бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалыг оролцогчид болон олон нийт танилцах боломжтой байдлаар нээлттэй байлгах, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, бүртгүүлэх” үүргийг хүлээсэн байх тул гүйцэтгэх үүргийн 2-т заасан үүргийн давтамжийг тооцоолох болно.

<sup>7</sup> “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

<sup>8</sup> “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллага үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

Мөн хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2.3-17.2.6-д заасны дагуу дээрх дүрэм, журам, аргачлалыг Холбооны Бүх гишүүдийн хурал батлахаар заасан бөгөөд мөн зүйлийн 17.1-д “Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулах бөгөөд ээлжит бус хурал зарлан хуралдуулахтай холбогдсон харилцааг Холбооны дүрмээр зохицуулна” гэж заасныг харгалзан давтамжийг нэг удаа байхаар тооцов.

**2.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:**

Энэ үе шатанд хуулийн төслийн дагуу шинээр хүлээсэн үүргийг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд гүйцэтгэхэд ямар хэмжээний захиргааны зардал гарах вэ гэдгийг “нэг бүрийн зардал”-ыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлэх замаар тооцоолох юм. Үүнийг томъёогоор илэрхийлвэл:

**НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ**

Хүснэгт 6

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал <sup>9</sup>
1	Холбоо энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалаас гадна дараах бичиг баримтыг Зөвлөлд хүргүүлнэ.	3,747,117 <sup>10</sup>	x	1	=	3,747,117
2	Энэ хуулийн 7.1-д заасан дүрэм, аргачлалыг Холбоо баталж, Зөвлөлд бүртгүүлнэ.	1,788,600 <sup>11</sup>	x	1	=	1,788,600

**2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2.6-д заасны дагуу Холбоо нь “бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалыг оролцогчид болон олон нийт танилцах боломжтой байдлаар нээлттэй байлгах, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх, бүртгүүлэх” үүргийг хүлээсэн бөгөөд тухайн үүргийг гүйцэтгэх хэлбэрийг тогтоосноор зардлыг бууруулах боломжтой гэж үзэв.

Тухайлбал дүрэм, журам, аргачлалыг бүртгүүлэхээр хүргүүлэхдээ цахим хэлбэрээр хүргүүлэх боломжтой бөгөөд энэ нь хуулийн этгээдэд цаг хугацаа, зардал

<sup>9</sup> “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

<sup>10</sup> хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш нэг удаа гарах зардал

<sup>11</sup> жил болгон хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

хэмнэх, нөгөө талдаа материалыг хүлээж авч буй төрийн байгууллагын хугацааг ч мөн хэмнэхээр байна.

## **2.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд тусгагдсан үүргийг хуулийн этгээд биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хууль тогтоомжоор тогтоосон төлбөр хураамж, үйл ажиллагаатай шууд холбоогүйгээр шинээр худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, материал зэрэгтэй холбогдон үүсч, шууд гарах мөнгөн зардлыг **нэмэлт зардал** гэсэн ойлголтод хамруулж ойлгодог болно.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад Холбоо нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байх тул Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно” гэж заасны дагуу тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах шаардлага үүсч байна. Иймд тусгай зөвшөөрлийг авахтай холбоотой гарах зардлыг нэмэлт зардал гэж үзнэ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “...тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн “Шаардлага, загвар батлах тухай” А/104 дүгээр тушаалын дагуу мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг хангахад нэмэлт зардал үүсэхээр байна.


Мөн тус тусгай зөвшөөрлийг авахдаа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д “их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг”-ийн тэмдэгтийн хураамж төлөхөөр заасан байна.

## **ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслөөр төрийн аль байгууллагад шинээр үүрэг бий болж, үүнийг дагалдан ямар зардал үүсэх вэ гэдгийг энэ хэсэгт тооцоолох юм. Ингэхдээ төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг дараах үе шатын дагуу тооцоолно.

Үүнд:





### 3.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох


Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд зааснаар дараах төрийн байгууллагууд зарим төрлийн үүрэг хүлээж байна. Үүнд:

- 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Бооцоот уралдааныг Засгийн газрын эрх олгосноор Монголын морин уралдааны холбоо /цаашид “Холбоо” гэх/ зохион байгуулна.” гэж заасны дагуу Засгийн газар;
- 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Зөвлөл нь бооцоот уралдааны эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна” гэж заасны дагуу мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөл;
- 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Зөвлөл нь бооцоот уралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөл тус тус хуулийн төслөөр шууд үүрэг хүлээсэн байна.

### 3.2. Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох:

Өмнөх хэсэгт тогтоосон чиг үүрэг, түүнд хамаарах ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, ажилтан ямар хугацаа зарцуулах болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа, /хэдэн иргэн, хуулийн этгэдэд/ гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн гурван үзүүлэлтээр шинээр нэмэгдэж буй чиг үүргийг хэрэгжүүлэхэд тухайн төрийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийн тоог тооцоолон гаргах юм.

Тодруулбал хуулийн төслийн дагуу үүрэг хүлээсэн төрийн байгууллага тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох замаар төрийн байгууллагын зардлыг тооцоолох бөгөөд шаардлагатай хүний нөөцийг дараах алхамыг гүйцэтгэнэ.



Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа уг ажлыг гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

**Зарцуулах хугацааг** тодорхойлохдоо чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил, үйлчилгээ буюу стандарт үйл ажиллагаагаар задалж, тухайн стандарт үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг салбарын мэргэжилтэнүүдтэй ярилцлага хийх, адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж баримжаалж тогтоов.

Үүрэг хүлээсэн төрийн байгууллага тус бүрээр тооцоолов.

**1.Засгийн газар:**

Хүснэгт 7

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Бооцоот уралдаан зохион байгуулах эрх олгох	Зөвлөлөөс ирүүлсэн дүгнэлтийн дагуу бооцоот уралдаан зохион байгуулах эрх олгох	24 цаг	1 <sup>12</sup>	24 цаг
	Хуралдааны шийдвэрийг албажуулах	16 цаг	1	16 цаг
	Шийдвэрийг олон нийтэд танилцуулах	8 цаг	1	8 цаг
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>48 цаг</b>

**2.Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд Зөвлөл гэдгийг Бооцооо таавар, хонжвот сугалааны тухай төсөлд заасан мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөлийг ойлгохоор эшлэсэн бөгөөд уг төсөлд зааснаар Зөвлөл нь дарга, 4 гишүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн гишүүнийг санхүүгийн, шударга өрсөлдөөн, аялал жуулчлалын болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тус тус санал болгосноор Засгийн газар 4 жилийн хугацаатай томилохоор тусгасан байна.

Зөвлөлийн орон тооны гишүүдийн тоог тодорхой зааж өгсөн боловч яг өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх Ажлын албаны орон тоо байхгүй тул үүнийг тооцоолох юм.

<sup>12</sup> Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд зааснаар морин уралдаан зохион байгуулах эрхийг нэг этгээдэд хугацаагүйгээр олгох тул тохиолдлыг тоо 1 юм.

**Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

Иймээс Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлангаар Зөвлөлийн орон тооны бус гишүүдийн тоо тодорхой байгаа тул Зөвлөлийн энэ хуульд заасан чиг үүрэгтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх Ажлын албанд шаардлагатай хүний нөөцийг тооцоолох юм.

Зөвлөл, түүний Ажлын алба нь мөрийтэй тоглоомын үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгагдсан байна.

Үүнд:

1.Бооцоот уралдааны эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулах<sup>13</sup>

2.Бооцоот морин уралдааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;<sup>14</sup>

3.оролцогч, унаач, уяачаас цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

4.Холбооноос шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;

5.Холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, морин тойруулгын тоног төхөөрөмжийг шалгах, магадлагаа хийх;

6.энэ хуульд заасан үүргийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих.<sup>15</sup>

Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Зөвлөлийн Ажлын албанд шаардлагатай хүний нөөцийг чиг үүрэг тус бүрээр дор тооцоолов.

Хүснэгт 8

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Бооцоот уралдааны эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулах	Бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх авахаар ирүүлсэн баримт бичгийг хянаж, судлах	120 цаг	1 <sup>16</sup>	120
	Бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх авах этгээд зохих шаардлагыг хангаж байгаа, эсэх талаар дүгнэлт гаргах	120 цаг	1	120
	Дүгнэлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	40 цаг	1	40
	Дүгнэлтийг холбогдох Засгийн газарт хүргүүлэх	20 цаг	1	20
	Шаардлагатай бусад ажиллагаа	20 цаг	1	20
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>320 цаг</b>

Хүснэгт 9

<sup>13</sup> Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5

<sup>14</sup> Хуулийн төсөлд тус заалттай холбоотой ямар ажиллагаа хийгдэх талаар тодорхой зохицуулалт байхгүй тул зардлын тооцоонд тусгаагүй болно.

<sup>15</sup> Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйл

<sup>16</sup> тохиолдлын тоо ижил



**Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Оролцогч, унаач, уяачаас цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;	Гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэх	2 цаг	100 <sup>17</sup>	200
	Гомдол, мэдээллийг шалгах	40 цаг	100	4000
	Шалгалтын дүнг гаргах	8 цаг	100	800
	Холбогдох хариуг гомдол мэдээлэл гаргагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх	4 цаг	100	400
	Шаардлагатай бусад ажиллагаа	2 цаг	100	200
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>5600</b>

Хүснэгт 10

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Холбооноос шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;	Тайлан хүлээн авах, танилцах замаар үйл ажиллагааны явцыг хянах	40 цаг	2 <sup>18</sup>	80
	Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар гаргуулан авахаар хандах	20 цаг	2	40
	Нэмэлт тайлбартай танилцах, холбогдох арга хэмжээ авах	40 цаг	2	80
	Шаардлагатай бусад ажиллагаа	20 цаг	2	20
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>220 цаг</b>

Хүснэгт 11

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн
---	---	-------------------	----------------	---------------

<sup>17</sup> Одоогоор Монгол Улсад энэ чиглэлийн үйл ажиллагаа явагддаггүй бөгөөд хэдий хэмжээний гомдол тоглогчоос ирэх нь тодорхойгүй тул дундаж төрийн байгууллагад ирдэг гомдлын тоогоор баримжаалан тохиолдлын тоог тогтоов.

<sup>18</sup> Тайлан, мэдээг хагас жил тутам хүлээн авдаг байна гэдгээр тохиолдлын тоог гаргав.

**Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

буюу ажил үйлчилгээ		цагаар		хэрэгцээ /цагаар/
Холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, морин тойруулгын тоног төхөөрөмжийг шалгах, магадлагаа хийх;	Тоног төхөөрөмжид шалгалт хийх	40 цаг	6	240
	Тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн бус бол шаардлагатай арга хэмжээг авах	40 цаг	3	120
	Шаардлагатай бусад ажиллагаа	8 цаг	3	24
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>384 цаг</b>

**Тодруулга:** Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын 4 тохиолдол тутмын нэгд тоног төхөөрөмжийг шалгах ажиллагаа явуулах боломжтой гэж үзэж тохиолдлын тоог гаргав. /Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын тохиолдлыг хүснэгт 12-т тооцов/ Үүнээс 50 хувьд нь буюу 3 удаад нь тоног төхөөрөмж хэвийн бус байх боломжтой гэж үзлээ.

Хүснэгт 12

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		цагаар		
энэ хуульд заасан үүргийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих.	<b>төлөвлөгөөт бус хяналт шалгалт</b>			
	төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж гаргах	8 цаг	24	192
	төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэх	40 цаг	24	960
	Хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авах	40 цаг	24	960
	Шаардлагатай бусад арга хэмжээ	24 цаг	24	576
	<b>гүйцэтгэлийн хяналт шалгалт</b>			
	гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж гаргах	8 цаг	12	96
	гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэх	40 цаг	12	480
	Хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авах	40 цаг	12	480
	Шаардлагатай бусад арга хэмжээ	8 цаг	12	96
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>3840 цаг</b>

**Тодруулга:** Зөвлөл нь шинээр байгуулагдах төрийн байгууллага бөгөөд энэ талаар өмнөх туршлага байхгүй тул тохиолдлын тоог баримжаалах байдлаар тогтоов. Хуулийн төсөлд тусгаснаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, хуулийн этгээдээс гомдол ирсэн тухай бүрт, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг хугацаатай албан шаардлагын биелэлтийг шалгах тохиолдол бүрт хийхээр байх тул төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг сард 2, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сард 1 удаа буюу жилд 36 удаа гүйцэтгэхээр тохиолдлыг тоог тооцов.

**Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт шаардлагатай хугацаа**

Д/д	Үүрэг хүлээсэн төрийн байгууллага	Шаардлагатай хугацаа
1	Засгийн газар	48 цаг
3	Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл /энэ хуулийн төслөөр хүлээсэн 6 төрлийн чиг үүргийн хүрээнд нийт/	10404 цаг

**Шаардлагатай хүний нөөцийг гаргах нь:**

**Засгийн газар**

Эрх олгохтой холбоотойгоор Засгийн газарт нэг удаа 8 цагийн ачаалал үүсгэж байгаа хүн орон тоо нэмэх шаардлагагүй буюу зардал үүсгэхгүй тул үүнээс хойш дахин зардал тооцох шаардлагагүй юм.

**Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл**


10404 цаг :  $8^{19}$  цаг = 1300.5 ажлын өдөр :  $200^{20}$  = 6,5 албан хаагч буюу тоймповол 7 албан хаагч энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд Зөвлөлд шаардлагатай байна.

**3.4. Гарах зардлыг урьдчилан тооцоолох**

Хуулийн хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн тоо нь тодорхой болсон тул тухайн төрийн байгууллагад хүний нөөцийг дагалдан дараах төрлийн зардал дагалдаж гардаг гэдгийг мөн харгалзах шаардлагатай. Өөрөөр хэлбэл хүн ажиллахад цалин хөлсний зардлаас гадна ажлын байрны зардал, бичиг хэргийн зардал, шаардлагатай техник хэрэгслийн зардал, бусад дагалдах зардлууд гардаг байна.

<sup>19</sup> Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн ажлын цаг

<sup>20</sup> Хуанлийн 365 хоногоос Хөдөлмөрийн тухай хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитойгоор ажиллах өдрийг 200 өдөр байхаар тооцохыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд заасан болно.



Харин манай улсад нэг төрийн албан хаагчийг дагалдан цалин хөлснөөс гадна ажиллах орчинтой холбоотой болон бусад нэмэлт зардал нь ямар байх асуудал одоо хүртэл нэгдсэн стандарт тогтоогүй тул зардлын тооцоог энэ хүргээд дуусгах нь зүйтэй байна.

## **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ**

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос хамааран хуулийн төсөл иргэнд аливаа төрлийн зардал үүсгэхгүй бөгөөд төрийн байгууллага болон хуулийн этгээд гэсэн хоёр субъектэд тодорхой төрлийн зардал үүсгэхээр байгааг тооцоолов.

Бооцоот морин уралдаан зохион байгуулах этгээдэд хуульд заасан баримт бичгийг бэлтгэхийн тулд нийт 419 цаг буюу 52 ажлын өдрийг зориулан, үүний цаана зөвхөн хүний нөөцийн захиргааны зардалд дундажаар 3,7 сая төгрөг зарцуулахаар тооцоо гарсан бөгөөд энэ нь хуулийн төслийн онцлогоос шалтгаалан хууль хэрэгжиж эхэлснээс хойш нэг удаа гарах зардал болохыг дурдах нь зүйтэй.

Харин Бооцоот морин уралдаан зохион байгуулах этгээд нь бооцоот уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалд өөрчлөлт орсон тухай бүрт Зөвлөлд бүртгүүлэх үүргийн хүрээнд нийт 200 цаг буюу 25 ажлын өдрийг зориулан, үүний цаана зөвхөн хүний нөөцийн захиргааны зардалд дундажаар 1,8 сая төгрөг зарцуулах тооцоо гарлаа.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг буруулах, хялбарчлах буюу бооцоот уралдаан зохион байгуулагч хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, аргачлалд өөрчлөлт орох бүрт бүртгүүлэхдээ цахим хэлбэрээр хүргүүлэх боломжийг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзлээ. Энэ нь хуулийн этгээдэд цаг хугацаа, зардал хэмнэх, нөгөө талдаа материалыг хүлээж авч буй төрийн байгууллагын хугацааг ч мөн хэмнэхээр байна.

Харин хуулийн этгээд нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь хуулийн этгээдийн тухайд нэмэлт буюу шууд төлөгдөх мөнгөн зардлыг үүсгэж байгаа хэдийн ч нөгөө талаас унаачийн эрх, түүнтэй холбоотой бусад оролцогчийн эрх ашгийг хамгаалах хуулийн зорилготой холбоотой тул зайлшгүй гарах зардал гэж үзэв.

Төрийн байгууллагын зардлын тухайд Засгийн газар болон хуулийн төслийг хэрэгжүүлэгч гол байгууллага болох мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан Зөвлөл шинээр байгуулагдаж байгаатай холбоотой хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөөр дамжуулан зардлыг тооцож үзэв.

Ингэхэд Засгийн газарт маш бага ачаалал үүсэхээр тооцоо гарсан тул зардал үүсэхгүй гэж үзэв. Харин Зөвлөлийн тухайд энэ хуулиар хүлээсэн чиг үүрэг бүрээр

ачааллыг тооцоход Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн хувьд нийт 7 албан хаагч шаардлагатай гэсэн тооцоо гарсан болно.

Энэ нь зөвхөн Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлд заасан чиг үүрэгт шаардлагатай хүний нөөцийн тоо бөгөөд шинээр байгуулагдах байгууллага тул нийтлэг чиг үүрэг болох албан бичиг, архив, хүний нөөц, санхүү төсөв, үйлчилгээний зэрэг үндсэн чиг үүрэгт туслах чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчид шаардлагатай болохыг мөн дурдах нь зүйтэй.

Нэгтгэн дүгнэвэл хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харилцааны тухайд гарах үр өгөөж нь зардлаас илүү байна гэж үзэхээр тооцоо гарлаа.

Түүнчлэн хуулийн төслийг дагалдуулж боловсруулсан Бооцоот морин уралдааны тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд хуулиар байгуулагдаж буй “Бооцоот морин уралдааны холбоо”-ны бүх гишүүдийн анхны хурлыг хариуцан зохион байгуулах субъект тодорхойгүй байх тул тухайн ажиллагаанд үүсэх зардлын тооцоог судалгаанд хамруулаагүй болно.

-----oO-----





Хууль зүй, дотоод хэргийн  
сайд Х. Нямбаатар танаа

## “МОНГОЛЫН МОРИН ТОЙРУУЛГА БОГИНО ЗАЙН УРАЛДААН УЯАЧДЫН ХОЛБОО” НҮТБ

6784135 Монгол улс Улаанбаатар хот  
Баянзүрх дүүрэг 13-р хороо Алтан тэвш АОС115 тоот

Утас: 9919-8784

2022.07.26 № 00/41.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Танилцуулга, хүсэлт

Монголын Морин Тойруулга, Богино Зайн Уралдаан Уяачдын Холбоо Нийгэмд үйлчлэх төрийн бүс байгууллага нь Монгол улсын нутаг дэвсгэрт импортоор орж ирж буй цэвэр цусны адуу, түүний төлийг бүртгэж гэрчилгээ олгох, Монгол улсад морин тойруулга ойрын зайн уралдааны үүсгэн хөгжүүлэх үндэс суурийг тавьж, мэргэжлийн унаач “Жокей” бэлтгэх сургалт явуулан олон улсын жишигт нийцсэн морин тойруулга, богино зайн хурдан морьдын уралдаан тэмцээн зохион байгуулах зорилготойгоор 2021 оны 11 сарын 12-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

2021 оны 12 дугаар сараас хойших хугацаанд Монгол улсад морин тойруулга, богино зайн уралдааны үүсэл хөгжлийг шинэ шатанд гаргахын тулд багагүй ажлыг төлөвлөн амжилттай зохион байгуулж байна. Үүнд:

1. Олон улсын жишигт нийцсэн морин тойруулга богино зайн хурдан морьдын уралдаан зохион байгуулах, мэргэжлийн унаач “Жокей” бэлтгэх зорилт тавин ажиллаж, Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, Монгол улсад анх удаа “Хан Монгол Морьтон холбооны сургалтын төв”-тэй хамтран жокейн сургалтыг явуулж, мэргэжлийн насанд хүрсэн 18-аас 30 насны жокей 20 хүнийг бэлтгэн, мэргэжлийн үнэмлэх, сертификат олгоод байна.
2. Монгол-Солонгосын спорт хөгжлийн холбоо (Дэд ерөнхийлөгч Ким Дун Конь)-той хамтран ажиллах, цаашид 2 орны хооронд жокей солилцох, туршлага судлах чиглэлээр хамтран ажиллах ажлыг эхлүүллээ.
3. Тус холбоо нь дээрх ажлуудыг хэрэгжүүлж, хууль дүрмийн дагуу хүртээмжтэй зохион явуулснаар өнөөдөр Монголын морин спорт уралдааны талаар нийгэмд үүсээд байгаа олон зөрчил маргаан, үл ойлголцол эрлийз морьдоо монгол морьдтой хольж уралдуулан уралдаан наадам будлиантуулах зэрэг сөрөг зүйлүүд арилж, Монгол наадам цогцолбор Хүй долоон худагт 7 хоногийн бямба, ням гарагт тогтмол уралдаан тэмцээн, морьт харвааны үзүүлбэр, морин циркийн үзүүлбэр, морин уналгын үйлчилгээ, хурдан морьдын дүүдлага худалдааг байнга зохион байгуулснаар гадаад дотоодын аялал жуулчлал хөгжих, хүүхэд залуучуудын чөлөөт



- цаг, танин мэдэхүйд маш чухал ач холбогдолтой юм. Мөн өвөл хаврын улиралд уяачид бага насны хүүхдээр хурдан морь унуулах, зөвшөөрөлгүй уралдаан тэмцээн зохион байгуулах явдал гарахгүй байх давуу талтай юм.
4. Тус холбооноос зохион байгуулж буй уралдаан тэмцээнд оролцох хурдан морьдыг холбооны дүрмийн дагүү 18 нас хүрсэн, зохих даатгалд хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхтэй Монгол улсын иргэн “Жокей” унаж тусгайлан зассан зам дээр 1-ээс 5 км хүртэлх зайд нэг гараанд 15 хүртэлх хурдан морьд уралдах ба ямарваа нэгэн тээврийн хэрэгсэл ашиглахгүй, дэвшилтэт технологи Дрон, камерын тусламжтайгаар олон нийтэд хүргэх тул ямарваа нэгэн осол эндэл гарах магадлалыг бууруулж байгаа онцлог юм.
  5. Монгол улсын Засгийн газар, Улсын Онцгой Комиссоос бүх шатны уралдаан тэмцээн, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулахыг зөвшөөрсөн тул 2022 оны 03 сарын 06-ны өдөр Сонгино Хайрхан Дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэр Монгол наадам цогцолборын харьяа Хурдан морь барианы газарт Монголын Морин Тойруулга, Богино зайн уралдаан уяачдын холбооны хаврын үйл ажиллагааны нээлт, Монгол улсад анх удаа мэргэжлийн жокей бэлтгэгдсэнийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Жокейн аварга шалгаруулах тэмцээн – MONGOLIAN CUP 2022”-ийг Хүй Долоон Хүдаг морь барианы газарт амжилттай зохион байгууллаа.

Тус уралдаанд газар газрын 24 хурдан хүлэг уралдаж, уралдааныг 500 гаруй үзэгчид үзсэн ба NTV телевизээр дамжуулсан болно.

Манай холбоо нь дээрх зохион байгуулсан ажлаа дүгнэн цаашид Монгол улсад богино зайн уралдаан, морин тойруулгын уралдаан хөгжих бүрэн боломжтой гэж үзэн доорх ажлуудыг дэс дараалалтайгаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлаа ханган зарим ажлыг эхлүүлээд байна.

Үүнд:

1. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, орчин цагийн морин тойруулга, хурдан морины уралдааныг сурталчлах зорилгоор Морь уналга, сургалт танин мэдэхүйн “МОНГОЛ БАХАРХАЛ” төслийг боловсруулан эхлүүлээд байна. Уг төсөлд хамрагдсанаар өсвөр үе, хүүхэд залуучууд үндэсний уламжлалт эрийн гурван наадмын талаар иж бүрэн мэдээлэлтэй болж, адуу мал тэжээвэр амьтадтай биечлэн танилцсанаар Эрүүл чийрэг зөв Монгол хүн болж төлөвшинө. “2022 он - Хотын иргэний жил”-ийн хүрээнд тусгагдсан ковидын дараах аялал жуулчлалыг сэргээх, үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах цогц хөтөлбөр хэрэгжинэ.
2. Морин тойруулгын спортыг хөгжүүлэх ажлын зайлшгүй хэсэг болох цэвэр цусны хурдан адууны үржлийг дэмжих зохих ангиллын хурдан морины тойруулгын уралдаанд бэлтгэх зорилгоор Монгол улсад анх удаа үржлийн адууны үзэсгэлэн дуудлага худалдааг цогц хэлбэрээр 2022 оны 05 дугаар сарын 18 нд Хүй долоон

худагт зохион байгуулахаар төлөвлөж, төслийг батлан олон нийтэд таниулан сурталчлаад байна.

3. Морин спорт уралдааны талаар уяачдын дунд үүсээд байгаа үл ойлголцол, зөрчил маргааныг шийдвэрлэх зорилгоор хурдан адууны богино зайн уралдаан “MONGOLIAN CUP – 2022” хоёр дугаар уралдааныг 2022 оны 05 сарын 15-ны өдөр Хүй долоон худагт зохион байгуулах бэлтгэл ажлаа хангаад байна.
4. Монгол улсын Засгийн газар, Хүй Долоон Худаг “Монгол наадам цогцолбор”-ийн ерөнхий төлөвлөгөөг баталсан явдал нь бидний цаашдын ажилд маш том ач холбогдолтой юм.
5. Хууль зүйн дотоод хэргийн яамнаас санаачлан Казиногийн тухай хууль, Морин бооцоот уралдааны тухай хуулийг Засгийн газарт өргөн барьж буйг сайшаан дэмжиж буйгаа үүгээр мэдэгдэж байна. Цаашид Морин тойруулга, Сонгодог морин уралдаан, Богино зайн уралдаан, Монгол улсад хөгжих үйл явцад маш чухал ач холбогдолтой юм.

Монгол улсад Морин тойруулгын спорт хөгжсөнөөр гадаад дотоодын аялал жуулчлал хөгжиж, цэвэр цусны адууны үржүүлэг хөгжин гадаад валютын урсгалыг дотооддоо төвлөрүүлэх боломж нээгдэнэ гэж үзэж байна.

Таны зохион байгуулах хуулийн хэлэлцүүлэгт оролцож, биечлэн үүлзан цаашид дэмжин хамтран ажиллах хүсэлттэй байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Зохих материал, төсөл төлөвлөгөөг хуулийн ажлын хэсэгт илгээв.

Хүндэтгэсэн:





## **Монголын морин тойруулга богино зайн уралдаан уяачдын холбоо Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага**

### **Төрийн бус байгууллагын зорилго нь:**

Монгол улсын нутаг дэвсгэрт импортоор орж ирж буй цэвэр цусны адуу түүний төлийг бүртгэж гэрчилгээ олгосноор, Монгол улсад морин тойруулга ойрын зайн уралдааны үүсгэн хөгжүүлэх үндэс суурийг тавьж мэргэжлийн унаач “жокей” бэлтгэх сургалт явуулан олон улсын жишигт нийцсэн морин тойруулга, богино зайн хурдан морьдын уралдаан тэмцээн зохион байгуулах зорилготой.

### **Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг явуулна.**

1. Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэх уяач, морины зүтгэлтэн, “жокей”, төрийн бус байгууллага, холбоод тус холбоонд гишүүнээр элсэхэд нээлттэй байна.
2. Монгол улсын нутаг дэвсгэрт импортоор орж ирсэн буюу ирж буй цэвэр цусны адуу түүний төлийг бүртгэж гэрчилгээ олгох
3. Монгол улсад морин тойруулга ойрын зайн уралдааныг үүсгэн хөгжүүлэх үндэс суурийг тавьж мэргэжлийн унаач “жокей” бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах
4. Олон улсын жишигт нийцсэн морин тойруулга, богино зайн (1.5км - 5км) хурдан морьдын уралдаан болон саадтай харайлтын уралдаан тэмцээн зохион байгуулах.
- Сар, улирал, долоо хоног тутамд D-1; C-1; A-1 ангиллын цэвэр цусны болон F-1-эрлийз морьдын уралдааныг тогтмол зохион байгуулах журам дүрмийг батлах, тэмцээн уралдаан зохион байгуулах
5. Олон улсын уралдаан тэмцээн зохион байгуулах эрх бүхий холбоодтой хамтран ажиллах
6. Үндэсний өв соёл уламжлалыг эрхэмлэн дээдэлж өсвөр үе хүүхэд залуучуудад сурталчлан танилцуулах
7. Дэлхийн морин спортын холбоо, Азийн морин спортын холбоонд гишүүнээр элсэх
8. Монгол улсад морин тойруулга ойрын зайн бооцоот уралдаан тэмцээн зохион байгуулах хууль эрх зүйн үндсийг санаачлан баталгаажуулах саналыг зохих шатны байгууллагаар шийдвэрлүүлэх
9. Уяач, уралдаанч, “жокей” хурдан морины зүтгэлтэн, хурдан удмын адууг алдаршуулах, шагнал урамшуулал олгох
10. Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
11. Гадаадын болон дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах
12. Төрийн болон хувийн байгууллагуудтай хамтарч ажиллах
13. Уулзалт семинар зохион байгуулах

Үүсгэн байгуулагч: Р.Гантулга (Утас:99198784, 94114111)



**МОНГОЛЫН ХАЛЗ ТУЛААНЫ  
ХОЛБОО ТББ**

Баянзүрх дүүрэг 15 хороолол

7-р хороо 23 байр 35 тоот

Утас:+976 90115069

+976 80812216

Й-мэйл: [a.uuganbayar222@gmail.com](mailto:a.uuganbayar222@gmail.com)

2022.05.25 № 022

№

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД  
Х.НЯМБААТАР ТАНАА**

‘Санал хүргүүлэх тухай’

Эрхэм хүндэт Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танаа.

Манай холбоо үүсгэн байгуулагдаад 6 жил болж байна. Энэ хугацаанд нийгэм олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төр нийгэмд тулгамдсан асуудалд гар бие оролцож ирлээ.

Өнөөдөр Монгол улсад бооцоот, мөрийтэй тоглоомын хууль санаачлагдан хэлэлцэгдэж байгаад туулийн их талархаж байгаагаа илэрхийлье.

Өнгөрсөн 2022.05.02-ны өдөр болсон казиногын тухай анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн явц үр дүнтэй урагшаа явж байгаад туулийн баяртай байна. Өнөөдөр Монгол улсад мөрийтэй тоглоом, бооцоот тэмцээний хууль зүйн орчин бүрдсэнээр аялал жуулчлал, шоу бизнесийн салбарууд хурдацтай хөгжих таатай орчин бий болно гэж хүлээж байна.

Иймд казиногын хуульд манай халз тулааны хуулийн саналыг тусгаж оруулж өгнө үү.

ХҮНДЭТГЭСЭН:

ТЭРГҮҮН  Г.БАТБОЛД

# МОНГОЛ УЛСЫН МӨРИЙТЭЙ, БООЦООТ ХАЛЗ ТУЛААНЫ ТУХАЙ ХУУЛЬ

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт.

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрийтэй, бооцоот халз тулааны үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Халз тулааны тухай хууль тогтоомж.

2.1. Халз тулааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл. Мөрийтэй, бооцоот халз тулааны үйл ажиллагааны зарчим.

Халз тулаан нь нээлттэй, ил тод, төрийн хяналт, шударга өрсөлдөөний зарчимд үндэслэнэ.

### 4 дүгээр зүйл. Хуулийн нэртөмьёо.

4.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1. "Халз тулаан" гэж энэ хуулиар тогтоосон журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдээс зориулалтын байр, танхим бүхий мөрийтэй, бооцоот халз тулаан зохион байгуулдаг газрыг

4.1.2. "мөрийтэй бооцоот" гэж халз тулааны төрөлд хамаарах, зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн халз тулааны төрлүүдийг; 4.1.3. "мөрий, бооцоо" гэж тэмцээний дүнг таамаглаж, урьдчилан бооцоо болгож тавьсан мөнгө болон түүнтэй адилтгаж болох зоос буюу чип, тасалбар зэргийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ .

### ХАЛЗ ТУЛААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХ

#### 5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1. Улсын Их Хурал "халз тулааны" үйл ажиллагаатай холбогдсон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Халз тулааны үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлогыг тодорхойлох

5.1.2. хуульд заасан бусад эрх.

#### 6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх.

6.1. Засгийн газар халз тулааны үйл ажиллагаатай холбогдсон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Халз тулааны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах

6.1.2. Халз тулааны үйл ажиллагаа явуулах байршлыг тогтоож, тогтоосон байршилд аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох;

6.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг санаачлагчын эрхээр журам батлах;

6.1.4. Зохицуулах хорооны саналыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах;

6.1.5. Зохицуулах хорооны бүтэц, дүрэм, дарга, гишүүдийг томилж, чөлөөлөх журмыг батлах;

6.1.6. Зохицуулах хороо байгуулах, гишүүдийг томилох, чөлөөлөх;

6.1.7. Хуульд заасан бусад эрх.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

### ХАЛЗ ТУЛААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

#### 7 дугаар зүйл.Халз тулааны үйл ажиллагааг зохицуулах.

- 7.1.Халз тулааны үйл ажиллагааг зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ нь халз тулааны үйл ажиллагааг зохицуулах, хянах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага байна.
- 7.2.Зохицуулах хороо нь ажлын албатай байна
- 7.3.Зохицуулах хороо энэ хуульд заасан чиг үүргээ аливаа этгээдээс хараат бусаар бие даан хэрэгжүүлнэ.
- 7.4.Зохицуулах хорооны бүтцэд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана
- 7.5.Зохицуулах хорооны дарга улсын ерөнхий байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг томилж чөлөөлнө.
- 7.6.Улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч тус тус олгоно.
- 7.7.Зохицуулах хороо нь үйл ажиллагаагаа жил бүр Засгийн газарт тайлагнана.
- 7.8.Зохицуулах хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### 8 дугаар зүйл.Зохицуулах хорооны бүрэн эрх.

- 8.1.Зохицуулах хороо нь халз тулааны үйл ажиллагаатай холбогдсон дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 8.1.1.Эрх бүхий байгууллагыг халз тулааны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр хангах, санал боловсруулах;
  - 8.1.2. Халз тулааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих
  - 8.1.3.Халз тулааны үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам баталж, мөрдүүлэх
  - 8.1.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх
  - 8.1.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, шалгалт хийх
  - 8.1.6.Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргуулах, эрх бүхий байгууллагуудад шилжүүлэх;
  - 8.1.7.Тусгай зөвшөөрөл цуцлуулах саналыг Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.
- 8.2.Зохицуулах хороо дараах дүрэм, журам, жагсаалтыг баталж мөрдүүлнэ:
  - 8.2.1.Халз тулааны нэр, төрлийн жагсаалт;
  - 8.2.2.Халз тулааны дүрэм;
  - 8.2.3.Мөрий, бооцооны доод, дээд жишиг хязгаар;
  - 8.2.4.Тэмцээний нэр төрлийн жагсаалт, түүнд тавигдах шаардлага;
  - 8.2.5.Бэлэн мөнгөний өрөөнд тавигдах шаардлага;
  - 8.2.6.Халз тулааны аюулгүй байдлын дүрэм;
  - 8.2.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон өргөдөл гаргагчийн талаарх мэдээллийг авах, нууцыг хадгалах;
  - 8.2.8.Халз тулааны үйл ажиллагаа явуулах байранд тавигдах шаардлага;
- 8.3.Зохицуулах хороо энэ хуульд зааснаас бусад дүрэм, журам батлахыг хориглоно.

#### 9 дүгээр зүйл.Зохицуулах хорооны хуралдаан.

- 9.1.Зохицуулах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 9.2.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

9.3. Зохицуулах хорооны шийдвэрт Зохицуулах хорооны дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

9.4. Хуралдаан сард нэгээс доошгүй удаа болох бөгөөд хуралдааны дэгийг Зохицуулах хороо өөрөө тогтооно.

9.5. Энэ хуулийн 9.4-т зааснаас бусад тохиолдолд зохицуулах хорооны дөрвөөс доошгүй гишүүн бичгээр хүсэлт гаргасан бол хорооны даргын шийдвэрээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

9.6. Хуралдаанаас гарах шийдвэр нь тушаал хэлбэртэй байна.

#### **10 дугаар зүйл. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг.**

10.1. Зохицуулах хороо нь дарга, 11 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг зохицуулах хорооны даргын саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

10.2. Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд

бүрэлдэхүүний тавин хувиас илүүгүй тооны гишүүнийг хоёр удаа улираан томилж болно

10.3. Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Засгийн газрын шийдвэр гарснаар эхэлж, чөлөөлсөн шийдвэр гарснаар дуусгавар болно.

10.4. Зохицуулах хорооны дарга, гишүүнд дараах этгээдийг нэр дэвшүүлэхгүй

10.4.1. Төрийн улс төрийн албан хаагч

10.4.2. Улс төрийн намын удирдах албан тушаалтан;

10.4.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

10.4.4. Халз тулааны үйл ажиллагаа эрхэлжбуйаж ахуйн нэгжтэй хамаарал бүхий этгээд;

10.4.5. Халз тулааны үйл ажиллагаа эрхэлж буйаж ахуйн нэгжийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

10.5. Зохицуулах хорооны дарга нь эдийн засаг, санхүү, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, Монгол Улсын иргэн байна.

10.6. Засгийн газар дараах үндэслэлээр зохицуулах хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

10.6.1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

10.6.2. Эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

10.6.3. Үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

10.6.4. Энэ хуулийн 10.4-т заасан албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;

10.6.5. Шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдсон.

#### **11 дүгээр зүйл. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг .**

11.1. Зохицуулах хорооны дарга хорооны гишүүний бүрэн эрхээс гадна дараах эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. Зохицуулах хороог дотоод, гадаадад төлөөлөх;

11.1.2. Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

11.1.3. Зохицуулах хорооны шийдвэрийн биелэлтийг хангуулах;

11.1.4. Зохицуулах хорооны гишүүдийн ажил үүргийн хэрэгжилтэд нь гүйцэтгэлийн хяналт тавих;

11.1.5. Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, түр чөлөөлөх, халах;

11.1.6. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн

11.2. Зохицуулах хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1. Зохицуулах хорооны хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх;

11.2.2. Зохицуулах хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох

11.2.3. Зохицуулах хорооны дүрэмд заасан ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан ажлыг хийж гүйцэтгэн, үр дүнг тусхорооны хуралдаанд тайлагнах



11.2.4.Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**12 дугаар зүйл.Улсын байцаагчийн эрх, үүрэг.**

12.1.Улсын ерөнхий байцаагч нь энэ хуулийн 12.2-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.Улсын ахлах болон байцаагчийн эрх олгох;

12.1.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг батла

12.1.3.Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

12.2.Улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10.9-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.Халз тулааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

12.2.2.Хяналт шалгалтын ажилд шаардлагатай баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулан авах;

12.2.3.Хяналт шалгалтын явцад зөрчлийн ул мөр, нотлох баримт цуглуулах, зөрчлийн талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор шалгагдаж байгаа этгээдийн бие, албан тасалгаа, бичиг баримт, компьютер, эд зүйлд үзлэг хийх, шаардлагатай баримт материал, эд зүйлийг түр хураан авах;

12.2.4.Захиргааны шийтгэл ногдуулах, тухайн шийдвэрийн биелэлтийг хангуулах;

12.2.5.Хяналт шалгалтын явцад холбогдох этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх;

12.2.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч холбогдох хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлуулах талаар Зохицуулах хороонд санал оруулах;

12.2.7.Халз тулааны үйл ажиллагааны явцын хяналтын дуу, дүрс, бичлэгийг тухай бүр шалгаж, хяналт тавих;

12.2.8.Шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол эрх бүхий байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;

12.2.9.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**13 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох.**

13.1.Халз тулааны үйл ажиллагааг Засгийн газраас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ

13.2.Энэ хуулийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийг өөр бусад этгээдэд шилжүүлэх, барьцаалах, худалдах, бэлэглэхийг хориглоно.

13.3.Энэ хуулийн 13.1-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1-т зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлж, Зохицуулах хороонд ирүүлнэ:

13.3.1.Тухайн этгээд энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт;

13.3.2.Халз тулааны үйл ажиллагаа эрхлэх төсөл;

13.3.3.хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл.

13.3.Шаардлагатай тохиолдолд зохицуулах хороо нэмэлт материалыг хүсэлт гаргагчаас авч болно.

13.4.Энэ хуулийн 13.3.3-т заасан баримт бичгийг Зохицуулах хороо хүлээн авч, ажлын 10 хоногийн дотор судлан, хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

13.7.Зохицуулах хороо энэ хуулийн 13.4-д заасан хугацааг ажлын 5 хоногоор сунгаж болно.

**14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг.**

14.1.Тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай олгож, мөн хугацаагаар сунгана



14.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө хугацааг сунгуулах тухай хүсэлтээ тусгай зөвшөөрлийн эх хувийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

14.3.Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногт багтаан энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, хугацаа сунгуулах саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

14.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол Зохицуулах хороо хугацаа сунгах боломжгүйг хүсэлт гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

#### **15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсэх.**

15.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хууль болон Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлагыг удаа дараа зөрчсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтны санал дүгнэлтийг үндэслэн Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж болно.

15.2.Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уг зөвшөөрлийг Зохицуулах хороо сэргээнэ.

15.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гаргасан зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй бол Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл цуцлуулах саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

15.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд халз тулааны үйл ажиллагаа явуулахыг хориглох бөгөөд Зохицуулах хорооноос байнгын хяналт тавьж ажиллана.

#### **16 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг цуцлах.**

16.1.Засгийн газар тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална

16.1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч 1 жилийн хугацаанд удаа дараа зөрчил гаргасан;

16.1.2.Зохицуулах хорооноос цуцлах талаар санал ирүүлсэн;

16.1.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, бэлэглэсэн, худалдсан;

16.1.4.Татварын зөрчил гаргасан;

16.1.5.Энэ хуулийн 18.4-т заасныг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

16.1.6.Хуульд заасан бусад үндэслэл.

16.2.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсон өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

#### **17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, .**

17.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

17.1.1.Хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажилласан тохиолдолд тусгай зөвшөөрлөө сунгуулах;

17.1.2.Хууль тогтоомжид заасан бусад эрх.

17.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

17.2.1.Монгол Улсын хууль тогтоомжийг биелүүлэх;

17.2.2.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлэх;

17.2.3.Засгийн газраас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг бууруулахгүй байх;

17.2.4.Улсын тэмдэгтийн хураамж төлөх;

17.2.5.Зориулалтын техник хэрэгсэл, сүлжээ, програм хангамж, хяналтын дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

17.2.6.Хууран мэхлэх, залилах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;

17.2.7. Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдүүлэх, мөнгө угаалт, терроризмтай тэмцэх үндэсний болон олон улсын байгууллагаас тавьж буй шаардлагыг биелүүлэх.

**18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага.**

18.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ажлын байр, техник хэрэгсэл, аюулгүй байдлын талаар дараах шаардлагыг хангасан байна:

18.1.1. Халз тулааны үйл ажиллагаа эрхлэх байрны нийт талбайн 75 хувиас доошгүй нь халз тулааны бус, олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан байх;

18.1.2. Халз тулааны үйл ажиллагаа эрхлэхэд зориулан тоноглогсон дуу болон дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан ажлын болон уулзалт, амралтын өрөөтэй байх;

18.1.3. Халз тулааны барилга байгууламж, тавилга, тоглоомын тоног төхөөрөмжүүд нь эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан, олон улсын стандартад нийцсэн байх;

18.1.4. Халз тулааны үйл ажиллагаа явуулж буй заал болон тамирчдын бэлтгэлийн өрөө бүрт дуу, дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан байх.

18.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнд хүрсэн байна.

18.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын арилжааны банкинд харилцах данстай байна. 18.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өдөр тутмын орлогоо энэ хуулийн 18.3-т заасан банкны дансанд байршуулна.

**19 дүгээр зүйл. Халз тулаантай холбогдуулан хориглох зүйл.**

19.1. Халз тулааны заал болон байр, түүний орчинд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно

19.1.1. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис үйлдвэрлэх, худалдах, хадгалах, хэрэглэх;

19.1.2. Биеэ үнэлэх, садар самуун явдлыг зохион байгуулах, сурталчлах, үйлчлүүлэх.

19.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, халз тулааны байрны албан тушаалтан, ажилтан дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

19.2.1. Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр тэмцээний дүрмийг засварлах, тусгай төхөөрөмжинд гар хүрэх, лацыг хөдөлгөх;

19.2.2. Халз тулааны тамирчныг мэхлэх үүднээс тэмцээний үр дүнг өөрчлөх, тоглоомын төхөөрөмжийн эд ангийг өөрчлөх, солих, тоглоомын төхөөрөмж болон программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;

19.2.3. Хожсон/ялсан/ тоглогчид хожлын төлбөрийг төлөхөөс зайлсхийх, татгалзах;

19.2.4. Тоглогч тамирчныг үргэлжлүүлэн тулалдах /зодолдох/-ыг ятгах;

19.2.5. Зохицуулах хорооноос зөвшөөрөгдөөгүй өөр төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах;

19.2.6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд халз тулааны үйл ажиллагаа эрхлэх, бусдад ийм үйл ажиллагаа явуулах бололцоо олгох;

19.2.7. Зохицуулах хорооноос хориглосон бусад үйл ажиллагаа.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.**

### **ТОГЛОГЧ/ТАМИРЧИН**

#### **20 дугаар зүйл. Тоглогч/тамирчин**

- 20.1.Халз тулааны тоглогч нь Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн байна.
- 20.2.Дараах этгээд тоглогч байхыг хориглоно:
  - 20.2.1. 21 насанд хүрээгүй этгээд;
  - 20.2.2.Монгол Улсын иргэн.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ.**

### **ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШАЛГАХ**

#### **21 дүгээр зүйл.Зөрчлийг хянан шалгах үндэслэл**

- 21.1.Халз тулааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаанд хянан шалгах ажиллагааг дараах үндэслэлээр явуулна:
  - 21.1.1.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл;
  - 21.1.2.Зохицуулах хорооны санаачилгаар;
  - 21.1.3.Хуульд заасан бусад үндэслэл.

#### **22 дугаар зүйл.Зөрчлийг хянан шалгах ажиллагаа.**

- 22.1.Улсын байцаагч зөрчлийг хянан шалгах ажиллагааг ажлын 20 хоногийн дотор явуулна.
- 22.2.Энэ хуулийн 22.1-д заасан хугацаанд зөрчлийг хянан шалгах ажиллагааг дуусгах боломжгүй бол уг хугацааг Зохицуулах хорооны дарга ажлын 10 хүртэл хоногоор сунгаж болно.
- 22.3.Улсын байцаагч хяналт шалгалтын ажлын дүнг уг ажиллагааг гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хорооны даргад танилцуулна.
- 22.4.Улсын байцаагч зөрчлийг хянан шалгахдаа зөрчлийн тухай тэмдэглэл хөтлөх, үзлэг шинжилгээ хийх, шаардлагатай эд зүйл, баримт бичгийг түр хураах эрхтэй бөгөөд энэ ажиллагааг явуулахад Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан журмыг баримтална.

#### **23 дугаар зүйл.Зөрчлийг хянан шийдвэрлэх.**

- 23.1.Зөрчлийг хянан шалгасан улсын байцаагч дараах шийдвэрийг гаргана:
  - 23.1.1.Зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэл ногдуулах;
  - 23.1.2.Тухайн зөрчлийг гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх.
- 23.2.Улсын байцаагчийн шийдвэрт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.
- 23.3.Улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлыг Зохицуулах хороо Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 23.4.Улсын байцаагчийн хяналт шалгалтын гомдлын талаар Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.
- 23.5.Улсын байцаагч нь халз тулааны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг хянан шалгах явцад болон эцсийн шийдвэр гараагүй байхад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хүндэд харш аливаа мэдээ, мэдээллийг тараахыг хориглоно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ.

### ХАРИУЦЛАГА

**24 дүгээр зүйл. Халз тулааны тухай хууль тогтоомжийг .**

24.1. Халз тулааны тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, Зохицуулах хороо зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан дараах захиргааны шийтгэл ногдуулна:

24.1.1. Тусгай зөвшөөрөлгүйгээр халз тулааны үйл ажиллагаа эрхэлсэн этгээдийн хууль бусаар олсон орлогыг хураан улсын орлого болгож, 50 000 000 төгрөгөөр торгоно.

24.1.2. Энэ хуулийн 18.4-т заасныг зөрчсөн этгээдийн тухайн өдрийн орлогыг хураан улсын орлого болгож, 10 000 000 төгрөгөөр торгоно. Энэхүү зөрчлийг хоёр буюу түүнээс дээш удаа гаргасан бол тусгай зөвшөөрлийг цуцална.

24.1.3. Энэ хуулийн 17.2.2, 17.2.5-т заасныг зөрчсөн этгээдийг 10 000 000 төгрөгөөр торгоно.

24.1.4. Энэ хуулийн 17.2.6, 19.2.7-д заасныг зөрчсөн этгээдийг 5 000 000 төгрөгөөр торгоно.

24.1.5. Энэ хуулийн 18-19 дүгээр зүйлд заасан шаардлагыг биелүүлээгүй этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлнэ.

24.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай албан тушаалтныг 10 000 000 төгрөгөөр торгоно.

Хуулийн төсөл санаачлагч нь Г.Батболд 91779911

А.Ууганбаяр 80812226

Хуулийн төслүүдийг олон нийтээр хэлэлцүүлсэн тухай  
ТЭМДЭГЛЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Казиногийн тухай, Бооцоот тоглоом, хонжворт сугалааны тухай болон Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг олон нийтэд танилцуулж, дараах хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно:

1.2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Казиногийн тухай, Бооцоот тоглоом, хонжворт сугалааны тухай болон Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлэгт Хөшигийн хөндийн бүтээн байгууллалтын захиргааны албаны төлөөлөл болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж, морин спортын холбоодын төлөөлөл, уяачид зэрэг олон салбарын 60 гаруй төлөөлөл оролцсон.

Хуулийн төслийн танилцуулгад Казино, бооцоот тоглоом хонжворт сугалаа, бооцоот морин уралдаан байгуулахад шаардагдах тусгай зөвшөөрлийн талаар, хөрөнгө оруулалт болон татварын зохицуулалтын талаар олон нийттэй санал солилцсон.

2.2022 оны 5 дугаар сарын 6-ны өдөр Казиногийн тухай хуулийн төслийн талаар Хөшигийн хөндийн бүтээн байгууллалтын захиргааны албаны төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хуулийн төсөлд тусгасан казиногийн тоглоомын төрлүүд болон мөрий тавих дээд хэмжээ зэрэг нарийвчилсан зохицуулалтын талаар санал солилцсон.

3.2022 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бизнесийн салбарын төлөөллүүд, морин спортын холбоодын төлөөлөл, уяачидтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг танилцуулсан бөгөөд тус уулзалтаар олон улсын практик туршлага, морин тойруулгын стандарт, нөхцөл, шаардлага, татварын асуудлаар санал солилцсон болно.

Танилцуулга, хэлэлцүүлгийн үед оролцогчдоос хуулийн төслүүдтэй холбогдуулан татвар, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага зэрэг асуудлаар санал дэвшүүлсэн бөгөөд зарим салбарын төлөөллөөс бичгээр санал ирүүлснийг судлан үзэж, холбогдох саналыг тусгасан болно.

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

Д/д	Нэр	Байгууллага	Утасны дугаар
1.	П.Сайнзориг	ХЗДХЯ Төрийн нарийн бичгийн дарга	88110079
2.	Д.Цолмон	ХЗДХЯ Хууль зүйн бодлогын газрын дарга	88101375
3.	Л.Пүрэвсүрэн	ХЗДХЯ Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн	88004418
4.	Б.Тэлмүүн	Сангийн яам Татварын бодлогын газрын дарга	264193
5.	Л.Нямдаваа	ЦЕГ	89008248
6.	н.Батчулуун	ЦЕГ	
7.	Д.Оюунхорол	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга	
8.	Б.Сэлэнгэ	Хөшигийн Хөндийн Бүтээн Байгуулалтын Захиргааны Албаны Хуульч	99177999